

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-46
1.Үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын явцын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох	3-46

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 17-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 23 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 60.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 23 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, П.Мөнхтулга, Г.Очирбат;
Чөлөөтэй: Г.Лувсанжамц, Д.Пүрэвдаваа, Б.Тулга;
Эмнэлгийн чөлөөтэй: П.Ганзориг, Ц.Даваасүрэн.

Нэг.Үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын явцын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Аж үйлдвэрлэл, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Довчинсүрэн, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, мөн газрын ахлах шинжээч Ч.Болдбаатар, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ч.Ариунтуяа, “Эрдэнэс үйлдвэрлэл, технологийн парк” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Мөнх-Идэр, “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жамуха, “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Мягмар, мөн компанийн зөвлөх инженер Д.Цэндсүрэн, менежер А.Анхзаяа, мэргэжилтэн О.Баярхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Г.Баярмаа нар байлцав.

Үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын явцын талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн

үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Замира, Д.Үүрийнтуяа, М.Бадамсүрэн, Б.Уянга, Л.Мөнхбаясгалан, Ж.Золжаргал, Д.Батбаяр, Д.Жаргалсайхан, С.Бямбацогт, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Мягмар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Жаргалсайхан, М.Бадамсүрэн, Ж.Золжаргал үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын явцын талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар нарын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 31 минут үргэлжилж, 23 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 65.2 хувийн ирцтэйгээр 16 цаг 54 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
14 цаг 23 минут.

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Ганбаатар: Байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Би та бүхэнд ирцээ танилцуулъя. Бадамсүрэн гишүүн 6 дугаар тойрог ирсэн байна. Дуламын Бум-Очир гишүүн ирсэн байна. С.Ганбаатар гишүүн 1 дүгээр тойрог ирсэн байна. П.Ганзориг гишүүн ирсэн байна. Даваасүрэн гишүүн өвчтэй байгаа юм байна. Жангабыл гишүүн ирсэн байна 3 дугаар тойрог, Д.Жаргалсайхан гишүүн ирсэн байна 1 дүгээр тойрог, С.Замира гишүүн ирсэн байна. Лувсанжамц гишүүн ирсэн байна. Лүндэг гишүүн ирсэн байна 5 дугаар тойрог, Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна 7 дугаар тойрог, Пунсалмаа гишүүн ирсэн байна. Б.Уянга гишүүн ирсэн байна. Д.Үүрийнтуяа гишүүн ирсэн байна 4 дүгээр тойрог, Энхцэцэг гишүүн ирсэн байна. Золжаргал гишүүн ирсэн байна. Ирц 56.5 хувьтайгаар хуралдаан эхэлж байна.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлаа би та бүхэнд танилцуулъя. Үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын явцын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсоно. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгаас Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд хандан 2024 оны 036094 тоот албан бичгээр Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт болон паркуудын үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл сонсох хүсэлтээ ирүүлсний дагуу өнөөдрийн хуралдаанаар дээрх асуудлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын мэдээллийг сонсоно.

Манай Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороогоор энэ сонсгол хийж байгаа явдал бол ард түмний мэдэх эрх Их Хурлын гишүүд ард түмний төлөөлөл болсны хувьд энэ мэдээллүүдийг бас ард түмэнтэйгээ хуваалцаж байгаа энэ том үйл ажиллагааны бас сонсгол хийж байгаатай адилхан шүү. Энэ чухал зүйл.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг би та бүхэнд танилцуулъя.

С.Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. Сайд чинь орж ирэх юм байгаа биз дээ? Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны томилолтоор ажиллаж байгаа юм байна. С.Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ирсэн байна. С.Сүхбат Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга ирсэн байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Ж.Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд ирсэн байна. М.Дондогдорж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга. Дондогдорж дарга ирсэн байна уу? Ирсэн байна. Г.Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга? Босоод танилцуулаад байгаарай. Н.Мөнх-Идэр дарга байна уу? “Эрдэнэс үйлдвэрлэл, технологийн парк” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Б.Жамуха “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал ирсэн байна. Б.Мягмар “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” ХК-ийн гүйцэтгэх захирал ирсэн байна. Холбогдох албаны хүмүүс ирснийг би та бүхэнд танилцууллаа.

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрхлэх асуудлын хамаарах үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын ажлын явц, цаашид үйлдвэрлэх асуудлын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр танилцуулна. Энхбаяр сайдад танилцах боломжийг өгье 4 номерын микрофон дээр

Ж.Энхбаяр: Манай үйлдвэрлэлийн асуудал хариуцсан газрын дарга Дондогдорж танилцуулга хийнэ. Тэнд очих уу, хаана болох вэ? Презентац тавих юм.

С.Ганбаатар: Тэгвэл энэ индэр дээр гараад презентац тавьж болно биз дээ? Индэр дээр урьж байна.

М.Дондогдорж: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль 2022 онд шинэчлэн баталснаас хойших хэрэгжилтийн талаарх товч мэдээллийг хийе.

Алсын хараа-2050-д хүнс, хөнгөн үйлдвэрийн паркийг бүсчилж байгуулахаар тусгачихсан байж байгаа. Өнөөгийн байдлаар хөнгөн үйлдвэрийн гэх юм бас Хөнгөн үйлдвэрийн хуулийн төсөл маань боловсрогдоод явж байгаа. Үндсэндээ 7 салбарыг хамрахаар хөнгөн үйлдвэрийн төсөлд тусгачихсан. Эдгээр салбаруудад маань манайх нийт 343 үйлдвэр, 1700 гаран ийм жижиг цехүүд үйл ажиллагаагаа явуулж, 45800 хүн ажиллаж байна гэсэн ийм статистик тоон мэдээлэлтэй байж байгаа.

Энэ дээр хүнсний салбарт бас нийт 978 үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ хөнгөн хүнсний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүдийг газар зүйн байршлаар нь бас та бүхэнд харуулах юм бол орон нутагт ерөнхийдөө анхан шатын үйлдвэрүүд нэлээн тархан байршсан байгаа. Энэ зураг дээр орон нутагт угаах үйлдвэрүүд аймгуудад байж байгаа. Энд хонь, тэмээний ноос, сарлагийн хөөвөр угаах ийм үйлдвэрүүд аймгуудад тархан байршсан.

Харин хялгас ялгах үйлдвэр гэх юм бол 3, 4 аймагт байгаа. Хялгас ялгах аас цаашид нарийн дамжлага болох ээрэх, нэхэх энэ шат дамжлага бүхий ийм цогцолбор үйлдвэрүүд Улаанбаатар хот, Эрдэнэт натурал, цэгцтэй ялаад Дархан гээд энэ гурван гол хотод энэ яг эцсийн гүйцэтгэн боловсруулах үйлдвэрүүд байршиж байгаа.

Арьс ширний үйлдвэрийн хувьд мөн адил. Боловсруулах үйлдвэрүүд Улаанбаатар, Дархан-Уул аймагт төвлөрсөн. Өвөрхангай аймагт жилдээ 1 сая арьс шир боловсруулах ийм анхан шатын арьс шир боловсруулах үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хувьд аймгуудад сүүний үйлдвэр, цехүүд ажиллаж байна.

Гол томоохон үйлдвэр мөн Сэлэнгэ, Улаанбаатар, Дархан гэсэн энэ том хотуудад сүүний томоохон үйлдвэрүүд, бусад аймгуудад жижиг хэмжээний цех үйл ажиллагаагаа явуулж байна.

Мал төхөөрөх үйлдвэрийн хувьд мөн адил. Бүх аймгуудад энэ мал төхөөрөх цех Улаанбаатар хот болон Дархан, гол аймгуудын төвүүдэд энэ боловсруулах үйлдвэрүүд байршиж байна. Нийт 135 үйлдвэр, цех энэ мал төхөөрөх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Гурилын үйлдвэр Хөвсгөл, Дорнод, Дархан, Улаанбаатар хотод төвлөрсөн нийт 9 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр сая та бүхэн статистик мэдээллээс харахад ерөнхийдөө яг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нэмүү өртөг шингэсэн энэ үйлдвэрүүд Улаанбаатар хот, Дархан, Эрдэнэт хотуудад энэ төвийн бүсэд энэ төвлөрсөн байдалтай үйл ажиллагаа явуулж байна. 2020 оноос хойш бас энэ хөнгөн хүнсний үйлдвэрийн салбарыг дэмжих чиглэлээр томоохон хууль, бодлогын баримт бичгүүд гарсан. Та бүхэн мэдэж байгаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт” энэ 2 үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлсэн. Улсын Их Хурлын тогтоолоор мөн Ноолуурын салбарт “Зарим арга хэмжээний авах зарим арга хэмжээний тухай” тогтоол батлагдаад 2 удаа хугацааг хойшлуулсан. Тэгээд 25 оны 7 сарын 1-нээс Монгол Улс зөвхөн самнасан ноолуур экспортлох энэ техникийн зохицуулалт мөрдөхөөр байж байна.

Үйлдвэрлэл, технологийн паркийн тухай хууль 2002 онд шинэчлэгдсэн багтсан. Анхны хууль 2007 онд батлагдсанаас хойш 2022 онд шинэчлэгдсэн батлагдсан. Энэ хуулийн дагуу Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар энэ үнэлгээ өгөх орон тооны бус зөвлөл байгуулагдаж Эмээлт, “Монэксалл” гээд 2 хуулийн этгээдээс үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаанаас тусгай зөвшөөрлийг авах энэ хүсэлтийн дагуу үнэлгээ хийж ингэж ажилласан байж байгаа.

Хөнгөн үйлдвэр, хүнсний үйлдвэрийн чиглэлээр хууль шинэчлэгдсэн батлагдсанаас хойш 2 үйлдвэрлэл, технологийн паркийн тусгай зөвшөөрлийг олгосон. Энд Эмээлт үйлдвэрлэл, технологийн парк. Энэ бол Улаанбаатар хотын Шар хөвийн хоолойд үйл ажиллагаа явуулж байгаа. Үйл ажиллагааг Улаанбаатар хотын дэргэдэх Эмээлт эко аж үйлдвэрийн парк гээд нийслэлийн өмчит ийм компани хариуцан хэрэгжүүлж байна.

Нөгөөдөх нь энэ Говьсүмбэр аймаг дахь Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологийн үйлдвэрлэлийн эко парк гээд тусгай зөвшөөрөл авсан. Энэ цэвэр 100

хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр ТЭЗҮ боловсрогдож Монгол Улсын Засгийн газраар хэлэлцэгдэж тусгай зөвшөөрөл олгочихсон.

Гурван үйлдвэрлэл, технологийн парк хууль шинэчлэгдэн батлагдахаас өмнө тусгай зөвшөөрөл авсан. Шинэ хуулийн дагуу авах ийм шаардлагатай ийм үйлдвэрлэл, технологийн паркууд байж байгаа.

Бүсчилсэн хөгжлийн хүрээнд бас энэ бид нар хөнгөн үйлдвэрийн паркийн байршлыг Улаанбаатар хот, Эмээлт үеийн энэ түрүүн сая Шар хөвийн хоолойд байх, Дархан-Уул аймагт Хөнгөн хүнсний үйлдвэрийн технологийн паркийг төвлөрүүлэн байршуулахаар ажиллаж байна. Мөн Ховд болон Говьсүмбэр Зүүн бүсэд Дорнод аймагт бас энэ үйлдвэрлэл, технологийн парк байгуулах энэ ажлыг, ийм бэлтгэл ажлыг бас эхэлсэн байж байгаа.

Нэг бүрчлэн танилцуулаад явчихъя.

Ховд үйлдвэрлэл, технологийн паркаас танилцуулъя. 2022 оноос эхлээд шинэ үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж эхэлсэн. Нийт 5 компани 5 дэд бүтцийн ажлыг гүйцэтгэж байгаа. Энд ер нь ер нь 100 үйлдвэр ашиглалтад орж 2000 гаран ажлын байр шинээр бий боллоо гэсэн ийм төлөвлөгөөтэйгөөр энэ үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн ажил эхэлсэн байж байгаа.

Үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий төлөвлөгөө энд байж байна. Энэ нийт ерөнхий хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг баталсан. Энэ төлөвлөгөөний дагуу суурьшлын бүс, үйлдвэрийн бүс, дэд бүтэц бүсүүдэд энэ үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцээ хуваарилаад үйл ажиллагааг шинэ Ховд гээд энэ аймгийн өмчит бас ийм компани хариуцаад явж байгаа.

Дэд бүтцийн хувьд нийт 35.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэнэ. Энэ нийт 5 дэд бүтцийн хөрөнгө оруулалтын ажил 2025 оны 9 сард бид нар бүрэн дуусахаар ажиллаж байна. Энд цахилгаан хангамж буюу 35 гига-гийн ийм шугам татна. Энд 5.6 тэрбум төгрөг, дулаан хангамж 14.2 тэрбум. Энэ дээр Ховд аймагт 2 дулааны станц байгуулж үйлдвэрийн зорилт уур гарахгүй учраас энэ ДЦС шинээр баригдаж байгаа байгаа. Одоо байгаа 2 дулаан станцаас болж тогтмол үйлдвэрийн зориулалтаар уур гарах боломжгүй дулаанаар бас хангах ийм боломжгүй учраас бас энд шинэ дэд бүтцийг бий болгож ингэж явж байгаа. 5 км хүнд даацын зориулалтаар авто зам баригдаж байгаа. 100 га-д нь инженерийн шугам сүлжээ хийгдэж байгаа. Холбоо хангамж, шилэн холбоог хангамжийн энэ 5 үндсэн дэд бүтцийн ажлууд хийгдээд 2025 ондоо бүрэн дуусахаар ингэж байгаа. 25 оны төсөвт үлдэгдэл 18 тэрбум төгрөг тусгачихсан байж байгаа.

Энэ Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн ажлууд нэг бүрчлэн танилцуулах юм бол энэ авто замын ажил, энэ ус зайлуулах шугам, цахилгаан хангамж 5 дэд бүтцийн ажлуудыг нэг бүрчлэн ажлын явцыг оруулсан байж байгаа.

Дараагийн үйлдвэрлэл, технологийн парк маань Дархан-Уул аймагт Төвийн бүсийн хөнгөн хүнсний үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн ажил байж байгаа. 2025 оны улсын төсөвт 7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бас яг энэ Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрийн парк. Энэ үйлдвэр, технологийн паркийн

дэд бүтцийн ажлаар тусгагдаад энэ ажлаа эхлэх гэхээр бэлтгэл ажлыг эхлээд явж байна.

Бид нар энэ хугацаанд энэ паркийн дэд бүтцийн байгаль орчны үнэлгээ, ТЭЗҮ, дэд бүтцийн ажлын зургууд хийгдээд магадлангийн шатдаа хийгдээд явж байна.

25 га маань тэр цэнхэр энэ дээрээс бид нар яг энэ дэд бүтцүүдээ татах энэ ТЭЗҮ-нүүд хийгдээд явж байгаа. Дулааны шугам гэхэд 2.8км-тэй, цэвэр усны 2км гэсэнчлэн яг энэ бүх техникийн нөхцөлөө аваад ажлын зураг маань, зураг төсөл маань магадлангаар хянагдаад дуусах шатандаа ороод явж байна.

Эмээлт эко аж үйлдвэрийн парк энэ маань бас нэлээн та бүхэн мэддэг байх. 2009 оноос хойш бас Эмээлт аж үйлдвэрийн парк байгуулна гэсэн энэ төлөвлөгөөнд тусгагдаад явсан. Энэ ажил маань 2022 оноос бас нийслэл өөр дээрээ энэ ажлыг нэлээн эрчимжүүлж, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар энэ ажлыг эхэлье гэдэг энэ байдлаар хийсэн. 2023 онд Дэлхийн банкны санхүүжилтээр техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн. Нийт 539 га дээр энэ Эмээлтийн үйлдвэр, технологийн парк байгуулахаар байгаа.

Эхний ээлжид 160 га дээрээ арьс ширний үйлдвэр, 8 сая арьс шир боловсруулах, арьс ширний боловсруулах үйлдвэрийг байгуулах энэ ажлыг бэлтгэл ажлыг эхлэхээр ажлыг эхэлсэн байж байгаа. Энэ графикчилсан төлөвлөгөөнүүд явж байна.

Хөрөнгө оруулалтын хувьд 2025 онд дулаан, цахилгаан 2 нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажлыг эхлүүлэе гээд нийслэлийн төсөвт тусгагдсан байгаа.

Энэ нийт үндсэндээ бид нар үйлдвэр, технологийн парк гэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зөвхөн дэд бүтцийн ажлуудыг хийе гэсэн энэ концепцын хүрээнд зөвхөн дэд бүтцийн ажлуудын ТЭЗҮ, төсвийн хөрөнгө оруулалтаар энэ ажлуудыг хийхээр тусгагдаад явж байгаа байгаа.

Сүүлчийнх нь энэ Говьсүмбэр аймгийн Баянтал дахь Мал аж ахуй, шинжлэх ухаан, технологийн үйлдвэрлэл, технологийн парк байгаа. Энэ парк маань хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр ТЭЗҮ боловсрогдож энэ паркийн тусгай зөвшөөрөл 2023 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдээд тусгай зөвшөөрлийг олгосон байж байгаа. Энэ паркийн хувьд газрын асуудал газрын дуудлага худалдаанд газрын бирж дээр орсон. Энэ асуудал маань шийдэгдэх юм бол энэ бүтээн байгуулалт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар энэ ажил эхлээд хэрэгжээд явна.

Энэ хөрөнгө оруулалтын хувьд энэ паркийн хувьд нийт нэлээн өндөр дүнтэй боловч бүх хөрөнгө оруулалт бол хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр эхнээсээ техник, эдийн засгийн үндэслэлд тусгачихсан учраас төсөв дээр ямар нэгэн дарамт гэдэг юм уу ирэхгүйгээр ингэж хийгдэх ийм паркийн үйл ажиллагаа байгаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Ганбаатар: Чухал мэдээллүүд өглөө. Энэ үйлдвэрлэл, технологийн парк дээр бас олон бас асуудлууд ярьж байгаа, хичээж байгаа. Тэгээд гишүүд энэ

материалуудыг, мэдээллүүдийг аваад, үзээд харж болно. Ард түмэнтэйгээ бас хамтдаа сонсож бид бас энэ дээр шийдэл гаргахын төлөө өнөөдөр сонсгол хийж байгаа.

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны эрхлэх асуудалд хамаарах үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын ажлын явц, цаашид шийдвэрлэх асуудлын талаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар танилцуулна. Жавхланбаатар дарга индэр дээр урьж байна.

С.Жавхланбаатар: Байнгын хорооны эрхэм дарга, эрхэм Улсын Их Хурлын гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны эрхлэх асуудлын хүрээнд үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагааны явц бүтээн байгуулалтын бэлтгэл ажил хэрхэн явагдаж байгаа талаар та бүхэнд товч мэдээлэл өгье.

Монгол Улсын Засгийн газрын 24-28 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 14 мега төсөл тусгагдсан байгаа. Энэ 14 мега төслөөс үндсэндээ 3 том төсөл маань цогцолбор хэмжээгээр, байдлаар хэрэгжихээр тусгагдсан. Энэ цогцолбор төслүүд маань аж үйлдвэрийн паркийн хүрээнд хэрэгжинэ гэж ойлгож болно.

Засгийн газраас саяхан улсын өмчит буюу төрийн өмчит үйлдвэрлэл, технологийн паркуудын байршлыг бол Засгийн газраар оруулж танилцуулсан байж байгаа. Та бүхэн эндээс харж байгаа шар өнгөөр будсан байршлууд маань төрийн өмчит буюу дэд бүтцийг нь улсын төсвийн хөрөнгө оруулалттай төрийн өмчийн компаниудын хөрөнгө оруулалттай байгууллага паркууд, цэнхэр өнгийн 2 парк маань хэрэгжээд явж байгаа орон нутгийн өмчит парк байж байгаа. Арай бүдэг цэнхэр өнгө маань, 4 парк маань хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай технологийн парк байж байгаа. Тавантолгой кокс эрчим хүчний цогцолбор, Бор-Өндөр жонш, цахиур боловсруулах цогцолбор, Эрдэнэт парк дээрх зэс боловсруулах цогцолбор, Дархан УТП дээр гангийн цогцолбор, Хөтөл УТП дээр барилгын материалын цогцолбор, Багануур УТП дээр химийн цогцолбор гэсэн ийм доторх төслүүд, томоохон төслүүд маань ийм байдлаар төлөвлөгдөж байгаа.

Би яг бодит хэрэгжиж байгаа 3 төслийг нь жишээ аваад та бүхэнд бас дэлгэрэнгүй танилцуулъя.

Эхний төсөл маань хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа. Дорноговь аймгийн Өргөн сумд хэрэгжиж байгаа, Алтанширээ сумд хэрэгжиж байгаа, Алтанширээт үйлдвэрлэл, технологийн паркийн төсөл байгаа. Хуулийнхаа дагуу Засгийн газрын тогтоол гаргаж газрыг нь тусгай хэрэгцээнд авч, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах эрхийг нь олгосон байж байгаа.

Үндсэндээ манай Үйлдвэрлэл, технологийн паркийн хуулиар тухайн хувийн хэвшилд хамгийн чухал 4 дэмжлэг үзүүлж байгаа. Энэ 4 дэмжлэг маань нэгдүгээрт бол энэ НӨАТ-ыг нь 4 жил хүртэл хугацаанд хойшлуулан төлүүлэх ийм. Яагаад гэвэл хувийн хэвшил маань энэ парк дээр дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг 100 хувь хариуцаж байгаа. Доторх төслүүдийн хөрөнгө оруулалтыг 100 хувь хариуцаж байгаа.

Хоёр дахь том чөлөөлөлт бол тоног төхөөрөмжөө гаалиар оруулж ирэхэд нь гаалийн төлбөрийг нь 4 жилийн хугацаанд мөн чөлөөлөх ийм дэмжлэг байж байгаа.

Дээр нь бол үл хөдлөхийн татвар, газрын татвараас чөлөөлж байгаа ийм дэмжлэгүүдийг хуулиар олгож байгаа. Тэгэхээр Алтанширээт технологийн паркийн хувьд төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтаас гурван талт гэрээнийхээ дагуу гаалиас бол 39 тэрбум төгрөг чөлөөлүүлэхээр төлөвлөгдсөн байна. НӨАТ-аас 81.9 тэрбум хойшлуулан төлөхөөр төлөвлөгдсөн ийм дэмжлэг үзүүлж байгаа.

Паркийн дэд бүтэц маань хэрхэн явагдаж байгаа талаар та бүхэнд харуулж байна. Одоогоор 40.7 тэрбумын хөрөнгө оруулалт хийгдсэн байгаа. Ингээд харах юм бол 6.3 мвт-ын цахилгаан станцыг 100 хувь барьсан. 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг үүнд зарцуулсан. Төмөр замын барилгын угсралт нь 12км төмөр зам 100 хувь дууссан. Хөрөнгө оруулалт нь 35.5 тэрбум, цахилгаан дамжуулах агаарын шугам 9.4 км холд татагдсан байж байгаа. Мөн 100 хувь дууссан 0.7 тэрбум хөрөнгө оруулалттай. Ус хангамж одоогоор хийгдэж байгаа. Дутуу байгаа. 15 хувьтай явж байна. 2.9 тэрбумын хөрөнгө оруулалт шаардагдана гэж харж байгаа юм.

Энэ дэд бүтэц маань бүрдээд Алтан ширээт үйлдвэрлэл, технологийн паркт маань юу бүтээн байгуулж, юу босгох гээд байгаа вэ гэхээр нийт хөрөнгө оруулалт нь бол тав аравны, нэг аравны таван их наядын хөрөнгө оруулалттай нүүрс баяжуулах үйлдвэр, коксын үйлдвэр энэ нь эрчим хүчний кокс, төмрийн хүдрийн нойтон соронзон баяжуулах үйлдвэр, төмрийн хорголжин үйлдвэр, ширэмний үйлдвэр гэдэг ийм үндсэндээ 5 ийм цогцолбор үйлдвэр баригдаад явж байгаа. Баригдаад явж байгаа.

Нийт орон нутаг, улс орон нь бол 432 тэрбум орчим татвар төлнө гэж төлөвлөгдөж байна. 2000 гаруй ажлын байрыг шинээр бий болгоно гэсэн ийм төлөвлөгөөтэй 28 онд бүрэн ашиглалтад орно гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Ийм парк байна.

Дараагийн парк. Дараагийн парк маань мөн Гэрэлт говь үйлдвэрлэл, технологийн парк байж байгаа. Түрүүний хэлсэн дэмжлэгүүдийн хүрээнд төр засгаас ямар дэмжлэг үзүүлж байна вэ гэхээр мөн газар, тэгээд үл хөдлөхийн татваруудаас бол чөлөөлж байгаа. Гаалийн чөлөөлөх дүн нь бол 13.3 тэрбум төгрөг, НӨАТ-аас 27-30 онд хойшлуулан төлөх нь 28 төгрөг тэрбум төгрөгийн хойшлуулан төлөлт төлөвлөгдсөн байж байгаа.

Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл маань 187 тэрбумд хүрсэн байгаа, төгрөгт хүрсэн. Баяжуулах үйлдвэрийн хөрөнгө оруулалт 65 тэрбум, 91 хувьтай явж байна. Төмөр замын бүтээн байгуулалт бараг дууссан. 98 хувьтай, 48 тэрбумын хөрөнгө оруулалт хийгдсэн. Коксын үйлдвэр цахилгаан хангамж бүтээн байгуулалтын үедээ явж байна. Нийт 70 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдана. 32 хувийн гүйцэтгэлтэй. Ус хангамжаа бол бараг шийдсэн 3.5 тэрбумаар.

Гэрэлт говь дотор маань үндсэндээ бол 2 л үйлдвэр баригдана. Нүүрс баяжуулах үйлдвэр, эрчим хүчний коксын үйлдвэр гэсэн. Нийт энэ үйлдвэрүүдэд

зарцуулагдах хөрөнгө оруулалт маань 507 тэрбум, мөн 28 онд бүрэн ашиглалтад орно гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Дараагийн төсөл маань 3 дахь төсөл маань Эрдэнэт үйлдвэрлэл, технологийн парк байж байгаа. Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар дэд бүтэц маань хийгдээд явж байна. 137.6 тэрбумын хөрөнгө оруулалт хийгдэж байгаа. Авто замын, 12.6км авто зам 45 хувьтай, төмөр зам нь 91 хувьтай бараг дууссан. 15.2 тэрбумын хөрөнгө оруулалттай. Цахилгаан хангамж нь бүтээн байгуулалт дууссан. 64.2 тэрбум. Ус хангамж, ариутгах татуурга 76 хувьтай гүйцэтгэл явж байна. Нийт 40 тэрбумын хөрөнгө оруулалт шаардлагатай ийм технологийн парк маань дэд бүтэц маань ингэж явж байгаа.

Энэ технологийн паркт маань Засгийн газрын түрүүн би дурдсан мега төсөлд орсон хамгийн том төсөл болох зэс баяжуулах, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр маань баригдана гэж төлөвлөж байгаа. Одоогийн урьдчилсан таамгаар 2.5 их наядын хөрөнгө оруулалттай ийм төсөл болно гэсэн таамагтай, ТЭЗҮ хараахан эцэслэн батлагдаагүй байж байгаа, үнэлгээ хийгдээд явж байгаа. Катодын зэсийг 125 мянган тонн боловсруулна. Алт 72кг, мөнгө 38 тонн, элементийн хүхэр 182 мянган тонн, хүхрийн хүчил 118 мянган тонн гэсэн ийм төлөвлөгөөтэй 29 онд ашиглалтад оруулна гэж төлөвлөсөн.

Нөгөө бусад төслүүд маань орон нутгийн өмчит Багахангай, Налайх, барилгын материалын үйлдвэр зонхилсон төслүүд маань хэрэгжээд явж байгаа. Гишүүдэд тараасан материал дээрээ шаардлагатай мэдээллүүдийг бол өгсөн байгаа учир бас би парк тус бүрээр танилцуулаад яах вэ гэж бодож байна. Асуулт байвал асуулт дээр тодорхой хариульа гэж бодож байна.

Бид нарт тулгамдаад байгаа бас зарим асуудлууд байгаа. Ер нь энэ үйлдвэрлэл, технологийн паркийг улсын хэмжээнд яг бодит үйлдвэрлэл болгоод, хөрөнгө оруулагч нарыг дэмжээд явахад үндсэндээ хуулийн хэрэгжилт маань нэг хууль гаргачхаад нөгөө бусад салбарын хуулиуд дээрээ очоод яг хуульдаа орсон ч дүрэм нь батлагддаггүй, журам нь батлагддаггүй гацсан байдалтай зарим асуудлууд байгаа юм. Ер нь үйлдвэрлэл, технологийн парктай холбоотой бид нар 12 журам батлахаас 7-г нь батлаад хэрэгжүүлээд явж байгаа. Үлдсэн 5 маань ямар асуудлууд дээр гацсан байна вэ гэхээр нэгдүгээрт энэ газрыг тусгай хэрэгцээнд авах асуудал байж байгаа. Мэдээж үйлдвэрлэл, технологийн парк дээр энэ түүхий эдийн хангамж, дэд бүтцийн хангамж, энэ бүх гол хөнгөлөлт үзүүлэх гэж байгаа юм маань нөгөө дэд бүтцэдээ хөрөнгө оруулаад тэр газар дээр л үйлдвэрлэл, бүтээн байгуулалтыг дэмжих зорилготой. Тэгэхдээ газраа яг бүрэн хуулийн хэмжээнд маргаангүй авах асуудал хөндөгдөж байгаа. Энэ маань журамдаа яг бүрэн тусаж өгөөгүй Газрын хуультай холбоотой.

Нөгөөдөх нь бол мэдээж энэ том бүтээн байгуулалтыг хийхэд дотоодын ажиллах хүч бол маш дутмаг байдаг. Дор хаяад 200-300 гадаад ажиллах мэргэжилтэн бүтээн байгуулалтын 2-3 жилд орж ирж ажилладаг. Энэ ажилтнуудыг төлбөрөөс чөлөөлөх хуулийн бол заалттай. Тэгэхдээ нөгөө ажиллах хүчнийг гадаадаас авах хуульдаа тусаагүй учраас журамдаа орж өгдөггүй нэг ийм асуудал байж байгаа.

Дээр нь мэдээж энэ түүхий эдийн хангамжийн асуудлууд нь бас саяын тэр дурддаг Гэрэлт говь, Алтан ширээг яагаад дурдаад байна вэ гэхээр анх төлөвлөж байгаа тэр кокс бэлдэх, үндсэн коксын нүүрс маань Тавантолгойгоос төлөвлөж

байгаа. Гэтэл Тавантолгойгоос яг үйлдвэр нь ашиглалтад ороход бүрэн хангана гэсэн баталгаа одоогоор хараахан хийгдээгүй. Ямар гэрээ, эрх зүйгээр Эрдэнэс Тавантолгойтой юм уу, орон нутгийн өмчит Тавантолгойтой хийх нь тодорхойгүй ийм байдалтай байж байгаа.

АМНАТ-ын асуудал бас хөндөгдөж байгаа. АМНАТ-ын асуудлыг Биржийн тухай хууль, бусад хууль дээр бид нар бас ярьж байгаа. Эд нар маань түүхий нүүрс дээрээ АМНАТ төлсөн мөртөөрөө дахиад боловсруулаад 2, 3 шат ахиулаад гаргахад дахиад АМНАТ-ын асуудал, төлөх асуудал хөндөгдөх үү гээд. Хөрөнгө оруулагч талаас ялангуяа энэ парк руу орж байгаа аж ахуйн нэгжүүд маань энэ асуудал дээр нэлээн санаа зовнилтой байгаа.

Мэдээж хөрөнгө оруулалт дээр бас бид нар энэ олон тэрбум, нэг наяд, их наяд гаруй ийм төгрөгүүд хийчхээд бас баталгаа байна уу гэдэг ийм асуудлуудыг хөндөж байгаа. Тэгэхээр энэ дээр бол яамны хувьд бас бусад яамнуудтайгаа хамтран ажиллахаар ажиллаж байгаа. Бодлогын хэмжээнд санал солилцоод холбогдох хуулиудад нь өөрчлөлт оруулъя гэсэн байр суурьтай ажиллаж байгаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Ганбаатар: Мэдээлэл өгсөн Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн даргад баярлалаа.

Манай гишүүд асуулт асууна. Ер нь цаад утгаараа үйлдвэрлэл, технологийн парк гэж Монголын аж үйлдвэрлэлийн локомотив болоод, манлайлал болоод явах. Энэ маань олон жил яригдаж байгаа, олон жил дэмжиж байгаа, олон жил яамнууд нь хичээж байгаа хувь, хувьсгалын олон паркуудын ажил хөл дээрээ босох гээд оролдож байгаа ч гэсэн нэг л дутуу цохиулсан үхэр шиг л л амь тавиад л л яваад байдаг. Үр дүн байхгүй. Хагалгаа их амжилттай боллоо, даанч өвчтөн үхчихлээ гэдэг шиг л аж үйлдвэрийн яг энэ гол магнат болсон энэ том том паркууд амжилтад хүрэхийн тулд эрх зүйн талаас нь бид яаж туслах вэ. Түрүүн 5 журам хэрэгжихгүй байгаа гэж ярьж байна шүү дээ. Эрх зүйн талаас нь бид яаж туслах вэ, Улсын Их Хурал дээр энэ дээр яг гол хуулийн хэрэгжилтийн хяналт тавихад бид яаж анхаарах вэ гэдэг дээр гишүүд маань санал, санаачилга гаргаад өнөөдрийн энэ сонсголыг хийж байгаа. Удахгүй ажлын хэсэг байгуулагдана, удахгүй шийдвэрүүд бас гарна. Гишүүд тодруулах, асуулт асуух гишүүдийн. Асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Далайн Батбаяр гишүүнээр тасаллаа. Замира гишүүн асуулт асууна.

С.Замира: Эрдэс баялгийн яамнаас асуух юм уу? Хөдөө аж ахуйн яамнаас асуух юм уу? Зэрэг явах юм уу хоёуланг нь?

С.Ганбаатар: Шууд зэрэг явчихна. Та тэгээд алианаас асууж байгаа вэ гэдгээ тодруулаад тодруулаад явчих.

С.Замира: За ойлголоо. Хүнс Хөдөө аж ахуйн яамны сайдаас тодруулах гэсэн юм. Энэ Эмээлтийн том цогцолбор барьж байгаа юм байна шүү дээ тийм ээ, бас тэр Эмээлтэд хэдэн жил асуудал үүсгээд тэнд баахан Хятадууд ирсэн байгаа. Бүх Монголын махны үйлдвэрүүд Хятадуудын эрх мэдэлд орсон байна гэж. Яг энэ хөрөнгө оруулалт хийж байгаа гадаадын хөрөнгө оруулагч нар юм уу, манай дотоодын хөрөнгө оруулагч нар энд үйлдвэр барьж байна уу?

Хоёрдугаарт, сая аж үйлдвэрийн парк байгуулахад юу гэж байна шүү дээ, газрын асуудал гээд. Тэр газрын асуудал нь юунаас л болоод зогсонги байдалд ороод байна? Энэ хоёр юмыг тодруулмаар байна.

С.Ганбаатар: Хариулт өгье. Эмээлт Эко аж үйлдвэрийн паркийн захирал Мягмар дарга хариулах юм байна. 1 номерын микрофон дээр нээж өгье.

Б.Мягмар: Сайн байцгаана уу? Замира гишүүний асуултад хариулъя.

Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн үндсэн 2 гол зорилго байдаг юм. Нэгдүгээрт, Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо, ер нь нийслэл Улаанбаатар хотод 3 дүүрэгт арьс ширний үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байгаа.

Ялангуяа Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо орчимд бол арьс ширний үйлдвэрүүд маань 20 гаруй үйлдвэрүүд бий. Харгиа цэвэрлэх байгууламж нь бол үйл ажиллагааны даац хэтэрсэн. Тухайн орчны ус, хөрсний бохирдол, үйлдвэрлэлүүд үйл ажиллагаагаа тэлж чадахгүй байгаа ийм байгаль орчны зайлшгүй нэг хүчин зүйл.

Хоёрдугаарт, арьс ширний салбар маань сүүлийн 10 гаруй жил бол ер нь бол эдийн засгийн хувьд нэлээн их хүнд хэцүү хөгжиж чадахгүй, арьс ширний үйлдвэрүүд нүүлгэнэ гээд бас олон жил болсон. Үүнийг Нийслэлийн Засаг даргыг Тамгын газрын зүгээс бол Эмээлтийн аж үйлдвэрийн паркийг нүүлгэн шилжүүлэх тухай суурь судалгааг Дэлхийн банктэй хамтарч сүүлийн 3, 4 жилийн хугацаанд хийсэн. Байршлын хувьд бол Эмээлт эко аж үйлдвэрийн паркд арьс ширний нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 20 гаруй үйлдвэрүүд нүүн шилжих нь эдийн засгийн хувьд бол илүү өгөөжтэй байна гэсэн ийм дүн гарсан байгаа.

Нөгөө талаараа бол Эмээлт эко аж үйлдвэрийн парк маань үндсэндээ эхний үе шат бол арьс ширний үйлдвэрүүдийг одоогийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арьс үнэ цэнгүй хаягдаж байгаа, Эмээлт орчимд хаягдаж байгаа арьс ширнийг нэмүү өртөг шингээж үйлдвэрлэлийн процесст оруулах ийм зорилгыг тавьж байгаа.

Нэгдүгээр асуудал бол сүүлийн 2 жилийн хугацаанд Нийслэлийн зүгээс хөрөнгө оруулалтыг нэлээн татахыг оролдсон. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар бол 8.9 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг Эмээлтийн паркийн Бизнес инкубатор үйлдвэр, сургалтын төв тухайн орчмын дэд бүтцийн суурь хөрөнгө оруулалт, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ гээд хийсэн. 2025 онд бол ДЦС цэвэрлэх байгууламжийг нийслэлийн зүгээс төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр ТЭЗҮ дулааны станцынх бэлэн болж, Эрчим хүчний ямаар батлагдсан. Одоо бол цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ 2 дугаар сард эцсийн байдлаар хүлээж авахаар бэлтгэл ажил хангагдаж байгаа. Ингэснээрээ бол Эмээлтийн паркийн төсөл, эхний үе шат бол арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр.

Одоогийн 2024 онд бол Эмээлтийн парк, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, мөн Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэмжлэгтэйгээр тусгай зөвшөөрөл авсан. Одоогийн байдлаар бол Арьс ширний 20 дугаар хороонд үйл ажиллагаа явуулж байгаа 4 арьс ширний үйлдвэрлэл ТЭЗҮ-ээ манайд ирүүлээд байгаа.

Тухайлбал, “Булигаар” хувьцаат компани, “Мон-Ирээдүй”, “Түмэн шир”, “Арилдий” гэсэн дөрвөн арьс ширний чиглэлийн үйлдвэрүүд ТЭЗҮ-ээ байгуулж ирүүлээд, нэгжийн гэрээ байгуулаад одоо газар ашиглах гэрээгээ байгуулах ийм бэлтгэл ажлууд хангагдаж байгаа. Тэгэхээр суурь дэд бүтцэд 400 орчим тэрбум төгрөг шаардлагатай. Нийслэл бол ирэх онд 200 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хувийн хэвшилтэй хамтарч дулааны цахилгаан станц, цэвэрлэх байгууламжийг барьж байгуулахаар ингэж төлөвлөж ажиллаж байгаа.

С.Ганбаатар: Замира гишүүн тодруулъя.

С.Замира: Би ер нь эзэмшигч хөрөнгө оруулагч яг энэ компаниудын эзэн аль улсын иргэн бэ? Манай Монгол Улс өөрснөө хийж байна уу, эсвэл гадаадынхан уу? Гадаадынхан байвал аль орон гээд асуусан л даа. Баярлалаа.

С.Ганбаатар: 4 номерын микрофонд Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Замира гишүүний асуултад хариулъя.

Ховд үйлдвэрлэл, технологийн парк улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үйлдвэрлэлийнхээ паркийн дэд бүтцийг нь барьж байгуулж байгаа. Дотор хийгдэх тэр ноос угаах, ноолуур боловсруулах, арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг хувийн хэвшил хөрөнгө оруулалтаар хийнэ. Өдий хүртэл энэ ажил олигтой явж өгөхгүй байгаагийн гол шалтгаан дэд бүтцийн зардал их өндөр болохоор хувийн хэвшил дийлэхгүй. Иймд ер нь төрийн оролцоо дэд бүтцийг нь хөрөнгө оруулалт дэмжлэг үзүүлэх хэмжээнд улсын төсөв дээр тавьж ингэж шийдэж яваа. Тэгэхээр эзэн гэдэг зүйл байхгүй. Энэ Ховд бол ийм байна.

Дархан мөн адилхан улсын төсвөөр дэд бүтцийн асуудал шийдэгдэнэ. Эмээлтийн парк бас мөн адил нийслэлийн төсөв дээр суугаад ажил нь явж байгаа. Хоёр санал байгаа нь Говьсүмбэр аймгийн Мал аж ахуй, шинжлэх ухааны технологийн парк гээд. Энэ бол хувийн хэвшил.../минут дуусав./

С.Ганбаатар: Энхбаяр сайдад нэмж, нэмэлт микрофон өгье.

Ж.Энхбаяр: Говьсүмбэр аймагт Мал аж ахуй, шинжлэх ухаан технологийн үйлдвэрлэл эко парк. Энэ бол хувийн хэвшлийн 100 хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр саналаа өгөөд, тусгай зөвшөөрлөө аваад явж байгаа.

Мөн Дорнод аймагт бас хувийн хэвшил, Дорнодын зүүн бүсийн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах ийм паркийн асуудлыг бас санал тавиад явж байгаа. Гэхдээ эцсийн зөвшөөрөл, засгаар орох асуудлууд нь газрын асуудал нь шийдэгдээгүй байгаа. Тэгэхээрээ Говьсүмбэр хувийн, бусад нөгөө 3 нь улсын төсөв дээр явж байгаа. Зөвхөн дэд бүтцийг оруулах, дотор барих үйлдвэрлэл хувийн хэвшил өөрсдөө хийх ийм хэмжээнд.

Тэгээд жоохон цаг алдаад байгаа шаардлага бол төсөв дээр бүрэн шийдэж өгөхгүй ингээд л урт хугацаанд л цувуулаад л яваад байна. Жишээлбэл, Дарханы хөнгөн.../минут дуусав./

С.Ганбаатар: Энхбаяр сайдад нэмэлт микрофон өгье.

Ж.Энхбаяр: Жишээлбэл, Дарханых гэхэд үндсэндээ 25 онд л анхны төсөв тавигдаж байна. 7.1 тэрбумд тавигдсан. Үүгээр дэд бүтцийг хийхэд хаанаа ч хүрэхгүй. Ер нь ахиухан тавиад богино хугацаанд хийгээд өгчихвөл цаана нь хувийн хэвшил маань өөрөө хүлээгээд байгаа юм. Хөрөнгө оруулаад явчих ийм саналууд нь их байгаад байдаг. Тэгэхээр мэргэжлийн Байнгын хороо энэ дээр бас дүгнэлт хийгээд нэг мөр ер нь олон газар бас байрлал алга. Бололцоотой 4, 5-хан газар дээрээ эцэслэн шийдээд нийт хөрөнгө оруулалтын дэд бүтцийг нь хурдан 26 онд гэхэд эцэслэн шийдээд өгчихвөл хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтууд нь бодитой үйл ажиллагаа болоод бужигнаад явчих гээд байгаа юм.

Тэгэхээр Ховд гэхэд л хэдэн жил бараг арваад жил явж байна даа тийм биз. Цуваад л яваад байгаа. Тэгээд энэ 25 онд Ховд үндсэндээ төгсөж байна. Дархан нь дөнгөж эхэлж байна. Эмээлт эхлээд 1, 2 жил болж байна. Ингээд төслөөр төсөвтэй холбоотойгоор ийм байгаа юм.

С.Ганбаатар: Ойлголоо Замира гишүүн тэр түрүүн хувийнх гэж байгаа, хувийнх нь өөрөө гадаадын хөрөнгө оруулалттай байгаа юу, аль нутаг орных вэ гэж тодруулж асуусан. Тэрийг нь хариулбал их сайн байна. 4 номерт.

Ж.Энхбаяр: Энэ Говьсүмбэр аймагт хийж байгаа төсөл гадаадын хөрөнгө оруулалттай. Энэ нь 64 хувь нь БНХАУ-ын хөрөнгө оруулалттай, 36 нь Монгол Улсын хөрөнгө оруулалттайгаар саналаа аваад, зөвшөөрлөө аваад ажлаа эхлэх гээд бэлтгэл ажлаа базааж байгаа ийм төсөл байгаа юм.

Эмээлт бол Эмээлтийн өмчлөлийн асуудал байгаа. Нийслэлийн.../минут дуусав./

С.Ганбаатар: 1 номерын микрофонд.

Б.Мягмар: Эмээлтийн аж үйлдвэрийн парк бол 100 хувь нийслэлийн өмчит, хаалттай хувьцаат компани байгаа. Эмээлтийн байршил бол СХД-ийн 32 дугаар хорооноос урагшаагаа Шувуун фабрик руу орох замд одоогоор бол Эмээлтийн 539 га газарт ямар нэгэн гадаадын болон дотоодын хувийн хэвшлийн аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулаагүй, цэвэр дэд бүтцээ тавина, үйлдвэрүүддээ газраа олгоно. Ингээд явах юм.

Тэгэхээр ямар нэгэн байдлаар гаднын хөрөнгө, оруулалт гаднын компани орж ирсэн тийм зүйл байхгүй 100 хувь нийслэл өөрсдөө улс, нийслэлийнхээ төсвийн дэмжлэгтэйгээр дэд бүтцээ тавьж өгнө. Хувийн хэвшлүүд өөрсдөө үйлдвэрээ барих ийм концепцоор явж байгаа.

С.Ганбаатар: Асуултдаа хариулт тодорхой авлаа. Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе.

2 яамны танилцуулга сонслоо. Хүнд аж үйлдвэрийн чиглэлээр үндсэндээ 12 үйлдвэр, технологийн парк, 4 нь хувийн хэвшил, орон нутгийнх болон төр нийлээд 8 байгаа юм байна гэж ойлголоо. Хүнс, хөдөө аж, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр бол 5 үйлдвэр, технологийн парк үүнээс 1 нь хувийн хэвшлээр, 4 нь төрийн өмчийн хөрөнгөөр дэд бүтцийн ажлууд нь хийгдэх юм байна. Ингээд бид нар үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд 17 үйлдвэрлэл, технологийн паркийн асуудлыг

төлөвлөж явж байгаа юм байна гэсэн ийм ойлголт мэдээллээс нь нэгтгээд харахад харагдаж байна.

Тэгэхээр нэгдүгээрт уул уурхай, эрдэс баялаг, эрдэс баялгийн чиглэлээр, хүнд аж аж үйлдвэрийн чиглэлээр ажиллахаар төлөвлөгдөж байгаа энэ үйлдвэрлэл, технологийн паркууд маань Хүнд үйлдвэрийн хуулийг боловсруулж байж орох ёстой юу, яах ёстой вэ? Хөдөө аж ахуйн яам сая Хөнгөн үйлдвэрийн тухай хуулийг боловсруулж байгаа гээд ярилаа. Тэгээд өмнөх парламентын Байнгын хороон дээр Хүнд үйлдвэрийн тухай хуулийг орж ирэхэд Хөнгөн үйлдвэрийнхээ хуультай нэгтгэх нь зүйтэй гээд буцааж байсан гэдэг мэдээллийг бид нар бас Байнгын хороон дээрээ авч байсан. Тэгэхээр энэ Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулиар бол яг энэ үйлдвэрлэлийн зохицуулалтыг бүрэн хийж чадахгүй байгаа. Тэгэхээр энэ Хүнд үйлдвэрийн тухай хууль тусдаа орох ёстой юу, яах ёстой вэ? Нэг.

Хоёрдугаарт, 2 яамны танилцуулж байгаа энэ 17 үйлдвэрлэл, технологийн паркийн байршлыг аваад үзэхээр байршлын хувьд давхардаж байгаа бүс нутгууд байна. Тухайлах юм бол Дарханд төвийн бүсийн хөдөө аж ахуйн чиглэлийн энэ үйлдвэрлэл, технологийн парк байх.

Дээр нь хүнд аж үйлдвэрийн чиглэлээр гангийн цогцолбор байгуулагдах үйлдвэрлэл, технологийн парк байх юм байна. Тэгэхээр энд уялдаа яаж хангагдаж явах ёстой юм бол? Давхардал байгаа газрууд дээр? 2 яамны хувьд барьж байгаа 2 хүнд, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр барьж байгаа үйлдвэрлэл, технологийн паркийн бодлогыг яаж уялдуулж ажиллаж байгаа юм бэ? Кластераар хөгжих талаас нь ер нь хамтад нь төлөвлөж байгаа, бодож байгаа асуудлууд байгаа юм болов уу? Аль алинаас нь асууя. 2 яамнаас.

С.Ганбаатар: Эхлээд Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга. 5 номерын микрофон. Дараа нь 4 номерын Энхбаяр сайд хариулна.

С.Жавхланбаатар: Гишүүний асуултад хариулъя.

Хүнд үйлдвэрийн хуулийг бол өмнөх парламентын үед бол тухайн үеийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас бас энэ эхний төсөл боловсруулаад өргөн барьж байсан юм байна лээ. Тэгэхдээ Байнгын хороон дээрээс буцаагдсан гэсэн мэдээтэй байгаа. Одоо Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, сайдын зөвлөл болон яамны зүгээс бид нар бас зөвлөгөөнөөрөө ярилцаад эхний ээлжид бол бид нарын тулгамдаад байгаа хууль бол Ашигт малтмалын тухай хууль байна. Тэгэхээр Ашигт малтмалын тухай хууль дээр нэгдүгээрт төвлөрье гэдэг ийм чиглэлтэй. Зэрэг бас 2 хууль дээр хүн хүчний асуудал байгаа.

Хоёрдугаар асуудал бол энэ Үйлдвэрлэл, технологийн паркийн хуулиа дөнгөж энэ 22 онд батлагдсан хууль. Тэгээд энэ хуулиа бүрэн хэрэгжүүлж үзье. Энэ хуулиас алдаа оноог нь харъя. Тэгж байж дараагийн хууль дээрээ нэмэлт зохицуулалт хийх үү, шинэ хууль байх уу гэдгээ ярилцъя гэсэн ийм чиглэлтэй ажиллаж байгаа.

Байршлын тухай хувьд бол бид нар бол саяын байршлуудыг Засгийн газраар хуралдаанаар ороход танилцуулахад ч гэсэн бас ярьсан байж байгаа. Ерөнхийдөө бол ТЭЗҮ дээрээ суурилад түүхий эдүүдийнхээ байршлыг л гол нь харж байгаа юм. Нэмүү өртөг шингээх гэж байгаа гол бүтээгдэхүүн, түүхий эд

маань яг орд маань хаана байна. Тэгээд дэд бүтэц нь байна уу гэдэг ий үндсэн асуудлуудаас нөхцөлүүдийг харж байгаад тэгээд Засгийн газар бол 12 сарын сая 4-ний өдрийн хуралдаанаараа эдгээр байршлыг бол дэмжсэн ийм шийдвэр гаргасан.

С.Ганбаатар: Энхбаяр сайд 4 номерын микрофонд.

Ж.Энхбаяр: Эрдэс баялгийн, энэ уул уурхайн үйлдвэрлэл яг түүхий эд дээрээ дагаж байршиж байгаатай адилхан гээд. Хөнгөн үйлдвэрийн салбар яг л энэ газар тариалангийн гол бүс, ажиллах хүчнийхээ гол бүс, дэд бүтцийнхээ нөөцдөө тулгуурлаж л явж байгаа.

Нөгөө талаас энэ эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гээд “Алсын хараа-2050”-д туссан тэр бодлогын дагуу бүс нутгийнхаа онцлог, мал аж ахуй нөгөө нүүдлийнхээ мал аж ахуйнд тулгуурлаад энэ хөдөө аж ахуйн үйлдвэрлэх энэ паркуудыг бүсчлэн байгуулна гэсэн энэ бодлогын хүрээнд бид баруун бүсдээ Ховд дээрээ төвлөрүүлэе. Урд говийн бүс дээр Говьсүмбэр дээр төвлөрч байгаа. Гол газар тариалангийн гол эрчим эрчимжсэн аж ахуйнууд төвлөрч байгаа Төвийн бүс дээрээ Дархан дээр төвлөрнө.

Тэгээд бас ажлын саналууд гараад байгаа. Дорнод буюу Чойбалсан хотод дараагийн нэг төв байх бүрэн бололцоотой гэж үзэж байгаа. Энэ хэмжээнд л манай яг нөөцөөр байрлалууд тэгж таарч байгаа юм.

Хуультай холбоотой, Хөнгөн үйлдвэрийн тухай хуулийг яам бүрэн боловсруулаад бэлэн болгосон. Бэлэн байгаа. Миний, манай санал бол энэ хүнд үйлдвэртэй холбох нэг хууль болгох нь тийм сайн зүйл биш. Энэ 2 эрс тэс, 2 өөр зүйл. Тэгэхээр тус тусдаа хуулиар нь явуулаад бэлэн болсноор нь манай Хөнгөн үйлдвэрийн тухай хуулийг хэлэлцээд, батлаад, энэ бодлого, Үйлдвэрлэл, технологийн паркийн хуультайгаа нийцүүлээд дараагийн ажлыг нь явуулбал уг нь зүйтэй байгаа юм.

С.Ганбаатар: Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Миний асуугаад байгаа зүйл хоорондын уялдааг л яриад байгаа юм л даа. Тэгээд нөгөө яамнууд маань яг л хариуцсан хариуцсан асуудлынхаа л Хөдөө аж ахуйн яам бол хөнгөн үйлдвэр, хүнсний чиглэлийн үйлдвэрүүдийнхээ паркийн асуудлыг яриад байдаг. Эрдэс баялгийн яам болохоор хүнд үйлдвэрийнхээ асуудлыг л яриад байдаг.

Гэтэл байршлыг ойлгож байна. Аль аль нь өөрсдийн нөөц, боломж, түүхий эддээ, мөн дэд бүтэцтэй тулгуурлаад л энэ байршлыг сонгож байгаа. Аль аль парк нь нэг бүс нутаг дээр байхаар орж ирж байгаа тохиолдолд хөрөнгө оруулалтын зардлаа хүртэл бид нар бас хэмнэх зорилгоор хамтад нь байгуулах бие биеийгээ дэмжих чиглэлээр хамтарч ажиллах кластер маягаар парк байх боломжийг харсан уу л гэдэг зүйлийг л би тодруулаад байгаа юм л даа.

2 чиглэлийн парк 1 аймаг дээр байгуулагдах нь л дээ. Дархан дээр жишээлэх юм бол, жишээ аваад хэлэхэд. Тэгэхээр яг энэ дээр, 1 минут нэмчхэж болох уу?

С.Ганбаатар: 1 минут нэмье.

Д.Үүрийнтуяа: Яг энэ чиглэлээр өөрөөр хэлбэл хөнгөн үйлдвэрийн салбарын хэрэглэгч маань өөрөө эргээд хүнд үйлдвэр хүнд, үйлдвэрийнхээ хэрэглэгч нь хөнгөн үйлдвэр, аж үйлдвэржилтийн бодлого буюу манай Байнгын хорооны бодлого бол энэ хүнд, хөнгөн үйлдвэрийг кластер маягаар бие биеэ дэмжиж хамтад нь хөгжүүлж байж л үр дүн гарна л гэдэг ийм бодлогыг бид барьж байгаа шүү дээ.

Хүнд үйлдвэрүүд явахдаа уул уурхай салбарын үйлдвэрүүд явахдаа ЖДҮ-лэлээ, хөнгөн үйлдвэрийнхээ бодлогыг дэмжиж, тэндээс орж ирж байгаа орлогын хуваарилалт нь ч гэсэн хөрөнгө оруулалт нь тэр бодлого руугаа чиглэж байх ёстой. Нөгөө эдийн засгийг солонгоруулах асуудал маань л энэ дээр яригдаад байгаа юм.

Тэгэхээр яамнууд маань тус тусдаа бодлого, үйлдвэрлэл, технологийн паркийн бодлогоо яриад явахаас илүүтэй нэгдсэн энэ кластер маягаар хөгжүүлэх асуудлаа яг байршлын хувьд давхцаж байгаа газрууддаа тусад нь авч үзэж ярихгүй юм уу л гэдэг зүйлийг л би хөндөж асуугаад байгаа юм л даа.

С.Ганбаатар: Тодруулах уу? Санал юм уу, тодруулах уу? Тодруулна. 5 номерын микрофонд Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга.

С.Жавхланбаатар: Гишүүний асуултад хариулъя.

Ер нь яах вэ хүнд үйлдвэр маань өөрөө хөнгөн үйлдвэрийн маань хэрэглэгч л дээ. 1000-2000 ажилтан тэнд ажиллана гэдэг маань өөрөө катеринг зардал гэж ярьдаг бид нар хоол хүнсний зардал, ажлын хувцасны зардал, бусад тэр ЖДҮ-лэлийг дэмжих зардал гээд. Одоо байгаа үйлдвэрүүд маань тэртээ тэргүй Өмнөговийг аваад үзэх юм бол Тавантолгой, Оюу толгой, хойшоо зэсийн Эрдэнэт үйлдвэрүүд эд нарын жишгийг аваад үзэх юм бол тэр хавийн малчид, өрхүүд маань ерөөсөө энэ үйлдвэрүүдээ түшиж амьдардаг ийм л юутай байгаа юм. Тэгээд яах вэ одоо энэ Дарханы ялангуяа төвийн бүсэд байгуулах гэж байгаа үйлдвэрүүд дээр хөнгөн үйлдвэрийн яамтайгаа бас бодлогоо уялдуулж харцгаая гэж бодож байна.

С.Ганбаатар: Сая Үүрийнтуяа гишүүний асуултыг бас дутуу л хариулчихлаа. Та нар бас тодруулаарай. Ер нь том утгаараа энэ чинь бас л кластер шүү дээ. Нарийн яривал бие биеийгээ л нөхөж ажиллана гэсэн үг. Эрдэс баялгийн томоохон хүнд үйлдвэрүүдийн паркууд маш олон бордооны эх үүсвэрүүд гаргадаг. Тэр нь Хүнс, хөдөө аж ахуйн яам буюу хөнгөн үйлдвэр, мал аж ахуйн паркууд дээрээ их дэмтэй байдаг гээд тэгээд гүйх нохойд гүйхгүй нохой саад гэдэг шиг одоо Хүнс, хөдөө аж ахуйн яам нь, Хөнгөн үйлдвэрийн яам нь бэлэн болчихлоороо зэрэг хүнд үйлдвэр нь эрх зүйн орчин яах вэ үйлдвэр, технологийн паркаараа явчихъя л гээд байдаг. Үүнийгээ та хоёр маань ярилцаарай.

Эцэст нь хэлэхэд Ж.Энхбаяр сайдын хэлдэг шиг тэгээд ямар уяатай нохой байгаа биш дээ. Тэр Хөнгөн үйлдвэрийн хуулиа яаралтай батлуулаад л явах байх. Аж үйлдвэрийн бодлогын байнгын хороо ерөөсөө дэмжье, эрх зүйн орчныг чинь яах вэ л гээд байгаа шүү дээ. Тэгээд Үйлдвэрлэл, технологийн паркийн хууль байхад тэр Хүнд үйлдвэрийн хууль бол хамаагүй ээ л гээд байдаг. Үгүй ээ яг нарийн яривал наад сая төсвийн хуулиар чинь орж ирэхэд үйлдвэрлэл, технологийн парк дотор гадна талаасаа илүү муу татварын нөхцөл бий болчихоод

байгаа шүү дээ. Энэ эрх зүйн орчнуудаа хэдүүлээ яаж янзлах юм бэ гэдгээ бас бодолцож шийдвэл их сайн байгаа.

Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: Танилцуулгыг сонслоо. Тэгээд гол нь төрөөс хэрхэн дэмжих вэ гэдэг зүйлээ л өнөөдөр энд танилцуулж байгаа гэж ойлгож байна. Энэ тулгамдсан асуудал гээд 5 асуудал лав Аж үйлдвэр, эрдэс баялгийн Төрийн нарийн танилцуулсан.

Нэгд нь энэ нөгөө улсын тусгай хэрэгцээний газрын Засгийн газрын 287 тоот журам. Энэ дээр нэмж оруулах гээд байгаа юм байна л гэж ойлгож байгаа. Энэ бол гүйцэтгэх засаглалынхаа хүрээнд Засгийн газартаа саналаа тавиад зүгээр жагсаалтад нь нэмнэ л гэсэн үг шүү дээ. Хууль дээр Үйлдвэрлэл, технологийн паркийн газар байгаа юм чинь. Энэ Байнгын хороонд бас, Байнгын хороо энэ шийдвэр гаргах юугүй байх гэж бодож байна.

Тэр нийлүүлэлттэй холбоотой зүйлийг яасан тэгээд энэ их чухал. Мэдээж тогтвортой түүхий эд нийлүүлэх. Үүнээс гадна нэгдүгээрт, энэ борлуулалтыг яаж дэмжих вэ урт хугацаандаа, тогтвортой. Энэ бол жинхэнэ төрийн хийх ажил. Өөрөөр хэлбэл гадаад зах зээлтэйгээ хэрхэн яаж уялдуулах вэ.

Ер нь манайд дутагдаад байгаа том юм байгаа шүү дээ. Яагаад гэвэл нөгөө өмнөд хөрш, бусад оронд чинь ийм бага хүүтэй, урт хугацаатай бизнесийн зээл их олгодог учраас энэ мөнгөө авч Монголын нутагт орж ирж л бизнес хийгээд байгаа шүү дээ ер нь. Уул уурхай руу бол аман дээрээс ирж нүүрс аваад байна л гэсэн үг. Энийг зохицуулахын тулд Биржийн тухай хуулийг баталж уул уурхайн бүтээгдэхүүнийг дуудлага худалдаа буюу биржээр борлуулж байгаа. Одоо нэг дутуу байгаа юм нь энэ Худалдааны тухай хуулийг их ойлгомжтой болгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл хил нөхцөлөөр, хилийн наа нөхцөлөөр, хилийн цаана гэсэн ийм олон улсын худалдааны нөхцөлийг манайх эрх зүйн орчныг нь их тодорхой болгож өгөхгүй бол мөнгөө бариад орж ирж Монголд бизнес хийх, Монголчууд нэмүү өртөг шингээж энэ үйлдвэрээ хөгжүүлэх асуудал чинь маш том гацаанд орно. Тэгэхээр энэ хамгийн том манай төрөөс хийх бодлогын ажил байхгүй юу.

Тэгэхээр Хөрөнгө оруулалтын хуультай зэрэгцээд худалдааны тухай энэ олон улсын нөхцөлүүдийг л тодорхой болгож өгнө. Тэгэх юм бол хөрөнгө оруулагчид болон худалдан авагчид маань Монголын төрд итгэх итгэл нэмэгдэнэ. Монголын аж ахуйн нэгжүүдтэй гэрээ хэлцлээ хийж, тохиролцож, харилцан ашигтай энийгээ арилжиж чадна. гэсэн үг.

Өөрөөр хэлбэл, манайд нефтийн бүтээгдэхүүнийг импортоор ОХУ-аас авахдаа дап дип гээд энэ нөхцөлүүдээс сонголт хийж авч байгаа юм. Хил үнэ гэдэг нөхцөлөөр авч байгаа. Өөрөөр хэлбэл, Оросын хил татвараа бүгдийг нь төлөөд дундын хилийн, 2 хилийн дунд орж ирэх үнээр манайх худалдаж аваад Монголын талынхаа татварыг төлөөд л ингээд оруулж ирж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ асуудлыг эрх зүйн хувьд нь төр их тодорхой болгохгүй, бас болохгүй байгаад байгаа юм гэдгийг энэ дээр бас хэлэх нь зүйтэй.

Дараагийнх нь бол дэд бүтцээр дэмжинэ. Ер нь энэ борлуулж байгаа бүтээгдэхүүн маань зах зээлдээ ойр буюу худалдан авагч талдаа ойрхон, эсвэл төмөр замдаа ойрхон байвал л эдийн засгийн үр ашиг гарна. Тийм учраас төр

ерөөсөө л энэ төмөр замдаа, боомтоос хот, төмөр замдаа ойр байх ёстой, дэд бүтэцтэй холбох ёстой. Энэ дээр хамгийн гол нөгөө гадагш борлуулах энэ сувгаа дэмжиж өргөтгөж өгөхгүй л бол ер нь болохгүй болчихоод байгаа шүү дээ.

Жишээлбэл, далайн тээвэр хамгийн хямд өртөгтэй, тэгээд зах зээлдээ очих хамгийн том тээвэр учраас л далай хамгийн ашигтай байдагтай адилхан бид нар энэ зүйл дээрээ бас анхаарах хэрэгтэй байгаа юм.

Дараагийнх нь тэр газар олголтоор дэмжих гэдэгтэй 100 хувь санал нэг байгаа. Ер нь төрөөс бизнесийг дэмжихийн тулд газрыг дуудлага худалдаагаар авбал тэгээд л бас хүндрэлтэй байдал үүснэ шүү дээ. Тэгэхээр нэгэнт л ажлын байр олон мянгаар гаргах гэж байгаа энэ зүйл учраас энийг дэмжих нь зөв.

Дараагийнх нь бол тэр байр барилгаар ийм томоохон байр барьж дотор нь ийм ялангуяа хөнгөн үйлдвэрүүдийг их хэмжээгээр оруулъя гэдэг тэр санал зөв л байгаа юм л даа. Энийг их тодорхой болгож дэмжиж өгөхгүй бол олон санал санаачилга байгаад байдаг. Эхний удаадаа хөрөнгө оруулж чадахгүй байгаа учраас компаниуд маань хөгжиж чадахгүй байгаа юм. Тэгэхээр би Ховдыг тэгж ойлгож байгаа. Манай Дорнодод ч гэсэн Энхбаяр сайдын хэлдгээр хувийн хэвшил санал тавьж байгаа энэ зүйлийг бас би дэмжиж өгөөч гэж.../минут дуусав./

С.Ганбаатар: Санал уу? Хариултаа авъя. Сая Бадамсүрэн гишүүн их чухал юм ажиглаж, бас гярхай хэлсэн байна шүү. Түрүүн Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн даргын илтгэл дээр гарсан 2 ч Засгийн газрын журам хэрэгжихгүй байна гэсэн Засгийн газрын журам шүү. Их Хурал бол хуулиа баталсан. Тэгээд 5 журам бас огт хэрэгжихгүй байгаа гэсэн энэ дээр Засгийн газар дотроо үнэхээр барахгүй байгаа бол бид өнөөдөр тэрийг нь хэрэгжүүлэх үү гэсэн тийм зүйлийг бас тодруулж асуусан. Хариулах байх. 5 номерын микрофон хариултаа өгье.

С.Жавхланбаатар: Асуултад хариулъя.

Түрүүн тодотгоод хэлэхэд яг Бадамсүрэн гишүүн бас нэлээн чухал асуудал хөндлөө. Бид нар энэ хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүнүүдийг худалдаалах, борлуулахдаа шинэ механизм оруулж ирэхгүй бол болохгүй болчихоод байгаа юм. Зөвхөн бирж бол өнөөдрийн явж байгаа бас бирж дээр дутагдалтай талууд байгаа. Олон улсад энэ урт хугацаанд хийдэг, энэ массаар үйлдвэрлэдэг, тэгээд үнэ нь ингэж зах зээл, олон улсын зах зээлтэй уяатай бүтээгдэхүүнүүд дээр бол маш олон механизм хэрэглэж байгаа. Одоо Фьючерсийн гэрээ хийж болно. Ирээдүйд олж авах гэрээнүүд хийж болно баталгаатай. Опционы гэрээнүүд хийж болно гээд энэ механизмуудыг Монголд нэвтрүүлэхгүй бол өөрөө зөвхөн манайд борлуулах урт хугацаанд худалдан авагчтай байх механизм маань баталгаагүй байж байгаа.

Тэгэхээр ялангуяа кокс хими, кокс эрчим хүч төслүүд бол химийн бүтээгдэхүүнүүдээ борлуулж болно. Эрчим хүчээ төвийн системд нийлүүлж болно. Гэхдээ кокс бол технологи болон урт хугацааны гангийн үйлдвэрлэлтэй холбоотой ийм асуудлууд байгаа. Тэгээд бид нар бас ТЭЗҮ-үүдийг авахдаа энэ өнцгөөс нь бас Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл дээр анхаарч ажилладаг гэдгийг хэлье.

Газар дээр тийм Ганбаатар даргын хэлдэг зөв. Бид нар энэ Үйлдвэрлэл, технологийн паркийн хуулийн 7 дээр болохоор заахдаа бол нөгөө Газрын тухай хуулиар журам баталж тусгай хэрэгцээнд авч гаргана гээд заачихсан. Тэгэхээр энийгээ бид нар нөгөө Засгийн газрын газрын агентлаг Геодез юу билээ,

агентлагтай хамтарч хийх ажил дутуу байгаа. Энэ Засгийн газрын хэмжээнд шийдэгдээд явж байна.

Нөгөөдөх нь тэр гадаад ажилчдыг төлбөрөөс чөлөөлөх асуудал байж байгаа. Энэ бол бас хуульдаа тодорхой хэмжээний өөрчлөлт орж байж явахаар ийм байгаа.

С.Ганбаатар: Энхбаяр сайд, 4 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя.

Энэ 5 дахь өдөр энэ үйлдвэрлэл, технологийн паркуудын төсөл, явц тэгээд хувийн хэвшлийн тэр санал бид нарын нэгдсэн маягаар яаман дээрээ хэлэлцүүлэг хийх гэж байгаа. Сонирхож байвал та ирэхийг бас урьж байна. Дорнод аймгаас санал тавьж байгаа аж ахуйн нэгжийн төлөөлөл бас ирж өөрсдийнхөө саналаа танилцуулгаар бэлтгэлээ хангасан байгаа.

Ер нь энэ худалдааны асуудал яригдсан худалдааных бол Монгол Улсад байхгүй. Энийг бас анхаармаар байгаа юм. Худалдааны зохицуулалт байхгүй үнэхээр. Худалдааны хуульгүй байж байж бид нар их том том гадаад гэрээнд ороход бас эрсдэл их өндөр гараад байгаа. Тэгэхээр Худалдааны хууль, энэ Демпингийн хууль гэдгийг ер нь анхаарч боловсруулахгүй бол тэр их дутагдаж байгаа.

Ж.Энхбаяр: Уянга гишүүн асуулт асууя. Тодруулах уу? Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Тэгэхээр энэ танилцуулгаас харахад бас олон аж үйлдвэрийн парк байгуулах ийм ажил бас явж байна л даа. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр ч явж байна, төрөөс ч явж байна. Тэгэхээр энэ их чухал. Яагаад гэвэл бид нар чинь хамгийн гол нь ажлын байр олноор гаргаад тэгээд олон хүн ажиллах юм бол олон хүн татвар төлнө, тэгээд Монгол Улсын сан хөмрөг нэмэгдэнэ. Эргээд түүгээрээ л том дэд бүтцийн төслүүд хийнэ, сургууль, цэцэрлэг, эмнэлгээ сайжруулна шүү дээ.

Тийм учраас яах вэ юу гэж хэлэх гээд байна гэхээр энэ үйлдвэрийн ажлууд явахтай зэрэгцээд энэ гадаад зах зээлийн нийлүүлэх энэ зүйлийг нь л төр маш сайн хийж өгөх хэрэгтэй л байгаад байгаа юм. Энэ бол нэгдүгээрт үүнийг л онцгой анхаараач ээ, Байнгын хорооноос ер нь хэрвээ шийдвэр гарахаар бол энэ зүйл дээр бас заавал тусгаж өгөөч.

Хоёрдугаарт, нь ер нь энэ газрын агентлаг маш удаан шүү. Би энийг аймгийн Засаг дарга байсны хувьд маш сайн мэдэж байна. Энэ тусгай хэрэгцээний газартай холбоотой асуудал дээр ерөөсөө шийдэхгүй удаад. Энэ хуульд чинь өөрчлөлт ороод

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүнд 1 минут нэмж өгье. Асуултаа тодруулъя.

М.Бадамсүрэн: Газрын тухай хуульд өөрчлөлт ороод үйлдвэрлэл, технологийн паркийг улсын тусгай хэрэгцээний газар дээр нэмээд энэ Засгийн газрын 287 дугаар журамд үйлчлэлд оруулахаар боломж олгочхоод байхад, 2 жил өнгөрчхөөд байхад, бараг 3 дахь жилдээ орох гэж байхад энийг Засгийн газрын

тогтоолд өөрчлөх ганцхан энэ хуульд оруулсан өөрчлөлтөө оруулж чадахгүй 2, 3 жил алдана гэдэг чинь аж ахуйн нэгжүүдийн, төр, хувийн хэвшлийн энэ үйлдвэр, технологи, хөнгөн, хүнд үйлдвэрийг хөгжүүлэхэд энэ төрийн энэ агентлаг ямар их гацаа болж байгааг л харуулж байгаа байхгүй юу. Ганцхан жишээ. Тэгээд өнөөдөр энийг Байнгын хорооны хуралдаан дээр энэ зүйлээ бүүр яамны Төрийн нарийн ядаад л Байнгын хороон дээр танилцуулж байна шүү дээ.

Тэгэхээр энэ манай Байнгын хорооноос гарах дүгнэлт, шийдвэр дээр бол заавал энэ газартай холбоотой зүйлийг хурдан шийдээч. Эрх зүйн хувьд Их Хурал тодорхой болгочоод байхад яагаад энийг шийдэхгүй байгаа юм бэ гэдэг. Энэ чинь 2, 3 жил алдагдсан боломж гэвэл аймаар олон зүйлийг ярина шүү дээ гэх мэтчилнээр дотоодынхоо энэ зохион байгуулалтын асуудал дээр бид нар анхаарах хэрэгтэй байна. Тэгэхээр энэ дээр онцгой анхаарч өгөөч. Тэгээд Энхбаяр.../минут дуусав./

С.Ганбаатар: Сая Бадамсүрэн гишүүний хэлсэн саналууд эндээс ажлын хэсэг гараад, бас тодорхой дүгнэлтүүд гараад, тодорхой шийдвэрүүд гарна. Энэ дээр бас нэлээн шийдлүүд нь гарах байх. Та нар ч гэсэн энэ дээр бас идэвхтэй ажиллах байх. Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Үйлдвэр, технологийн паркийн тухай хууль дээр зааснаар үйлдвэр, технологийн паркийн зориулалтаар газрыг эзэмшиж байгаа, ашиглаж байгаа энэ талбай, энэ паркийн талбайд болохоор их олон хөнгөлөлтүүд бий болсон байгаа. Газрыг эхний 10 жилд газрын төлбөрөөс чөлөөлнө, паркийн нутаг дэвсгэр дэх үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас эхний 5 жилд чөлөөлнө, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг албан татварын төлөх хугацааг нь 4 жил хүртэлх хугацаагаар сунгана, хөрөнгө оруулалт дээр Засгийн газрын баталгаа гаргуулна гээд нэлээн олон тийм хөнгөлөлтүүд байгаа. Тэгэхээр энийгээ мэдэж байгаа тохиолдолд хувийн хэвшил яг энэ үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулъя гээд орж ирэх болов уу гэсэн бодолтой байгаа байхгүй юу.

Тэгэхээр ер нь паркийн байршлын сонголтыг хэрхэн хийсэн бэ гээд хоёр яамнаас хоёулангаас нь асууя. Тэгээд Энхбаяр сайдын танилцуулгад дэд бүтэц, тэр эрчим хүчний асуудал, бусад холбогдох дэд бүтцийг нь, хөрөнгө оруулалт ихээр шаардах учраас төрөөс заавал тавьж өгөх ёстой. Тийм учраас төрийн оролцоо байх ёстой гэдэг байдлаар асуултуудад хариулж байдаг.

Харин Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болохоор энэ Гэрэлт говь, Алтанширээт гээд байгаа тэнд байгаа дэд бүтцүүдийг бүгдийг нь хувийн хэвшил хийсэн байдаг. Тэгэхээр яг хөнгөн үйлдвэр талдаа болохоороо дэд бүтцийг нь төр хариуцах хэрэгтэй болоод, хүнд үйлдвэр талдаа болохоор магадгүй тэр хөрөнгө оруулалтын хэмжээ, орж ирж байгаа мөнгөн урсгал эд нараасаа хамаараад тэр компаниуд нь хувийн хэвшил нь өөрсдөө дэд бүтцээ шийдээд байх шиг ийм том 2 ялгаа байгаад байх шиг харагдаад байна л даа.

Тэгээд энийг л яг энэ уялдуулах дээр нь энэ манай Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гарах ажлын хэсэг ажиллана. Тэгээд түрүүн Үүрийнтуяа гишүүний асуусан асуулт яг зөв байгаа шүү дээ тээ. Хоорондоо хөнгөн,

хүнд үйлдвэрүүд уялдах ёстой. Хэрвээ хөнгөн үйлдвэрүүд нь хүнд үйлдвэрүүддээ ашиглагдаад тэндээс гарах бүтээгдэхүүнүүд нь хүнд үйлдвэрүүддээ хэрэглэгдэх юм бол уялдаад тэрэнд нь дэд бүтцийг нь яаж зохицуулдаг болох юм бэ гэдэг дээр бодоод сууж байхад паркуудын байршлын сонголтыг хэрхэн хийснийг нь сонсмоор байна.

Тэгээд энэ паркийн хуулийг уншаад үзэхээр аль ч аж ахуйн нэгж, хувийн хэвшил зориглоод ороод ирэхэд боломжтой нөхцөл нь бүрдчихсэн юм шиг ийм байдлаар харагдаж байна. Тэгээд энэ дээрээ бүгдээрээ асуулт асуугаад, хариултаа авах байх.

Хөнгөн үйлдвэрийнхний танилцуулсан танилцуулгад хангайн бүсийн 3 аймагт огт тийм үйлдвэрлэл, технологийн парк байгуулна гэсэн тийм байршил ч харагдсангүй. Энэ дээр бас хариулаад өгөөч. Ямар нэгэн асуудал байгаа юу, эсвэл төлөвлөгдөж байгаа юу?

С.Ганбаатар: Уянга гишүүний асуултад хариулъя. Эхлээд 5 номерын микрофонд Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга хариулна, дараа нь 4 номерын микрофонд Ж.Энхбаяр сайд хариулна.

Уянга гишүүний асуултад хариулъя.

С.Жавхланбаатар: Үйлдвэрлэ, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль маань саяын таны хэлдэг ер нь 9 тодорхой дэмжлэг байгаа. 9 тодорхой дэмжлэг хуульдаа заасан байгаа. Бусад хуулийн дэмжлэгийг бас ашиглана гэсэн. Тэгээд хувийн хэвшлийн ялангуяа 3, саяын миний 2 танилцуулдаг бүтээн байгуулалт нь нэлээн ахичихсан хөрөнгө оруулагч нартай уулзахад энэ маш чухал хууль болсон. Ялангуяа хөрөнгө оруулалтын эхний үе шатад кэйш флов/cash flow/ дээр авч байгаа, мөнгөн урсгал дээр авч байгаа дарамт бол саяын нөгөө гааль, НӨАТ-ын татварын чөлөөлөлт, хойшлуулалт бол маш чухал болсон гэж байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаар дэмжлэг бол саяын тэр газрын баталгаа, эрх зүйн баталгаа. Тусгай хэрэгцээнд авч технологийн парк гэж байгуулаад дотор нь хөрөнгө оруулалт хийж байгаа хүн, тэрний гадна талд хийж байгаа хүн хоёрын ялгаа, өрсөлдөх чадвар маш өндөр болсон гэдгийг хувийн хэвшлийнхэн хэлж байгаа юм.

Хувийн хэвшил, улс гээд түрүүн Засгийн газраар орсон 6 мега төслийн байршил маань дэд бүтэц нь улсын хөрөнгө оруулалттай. Улсын гэдэг маань бид нар тэгэхдээ тухайн төрийн өмч, ордоо эзэмшиж байгаа төрийн өмч маань Эрдэнэс ҮТП гээд Эрдэнэс Монголын доор байж байгаа. Эдний менежментийг л манай яам бодлогоор дэмжиж байгаа. Өөрөөр хэлбэл, тэр төрийн өмчийн үйлдвэрүүд маань ашигтай ажиллах ёстой. Тухайн ашгаасаа гаргаж, илүүчилж энэ үйлдвэрлэл, технологийн паркуудынхаа дэд бүтэц рүү хөрөнгө оруулалтаа хий.

Харин барих гэж байгаа үйлдвэр дээр бол олон улсынхаа санхүүгийн зарчмаар зээл, хөрөнгө оруулагчийн асуудал, технологи эзэмшигчийн асуудал ярья гэдэг ийм бодлоготой явж байгаа гэдгийг тодотгоё.

С.Ганбаатар: 4 номерын микрофонд Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Байршлыг хэрхэн сонгосон бэ гэдэг асуудал байна. Ховдоос эхэлье. Ховд бол Баруун бүсийн тулгуур төв. Нөгөө талаасаа ОХУ, БНХАУ дамжсан Евро Азийг холбосон олон улсын ийм авто замын яг уулзвар дээр байгаа. Олон улсын 2 боомт руу гарах гарцтай гэсэн үг. Тэгээд тэрийгээ дагаж бас зах зээл рүүгээ ойртож хийсэн байх. Нөгөө талаасаа түүхий эдийнхээ нөөц дээр дагаж байсан.

Дархан ойлгомжтой. Дархан бол нийт 21 аймгаас ганц дэд бүтцийн нөөц байгаа аймаг. Үйлдвэрлэлийн дулаан, уур, ус цэвэрлэх байгууламжийн нөөц Дархан хотод 20, 30 хувь байна. Бусад аймгуудад ийм бололцоо үндсэндээ байхгүй.

Улаанбаатар хотын тухайд дэд бүтцийн асуудал нэлээн хүндэрсэн. Эмээлт өөрөө мал аж ахуйн гаралтай түүхий эдийн том худалдааны төвлөрөл, арилжаа явагддаг. Тэгээд Эмээлтдээ тулгуурлаад дэргэд нь энэ Улаанбаатар хотод байгаа арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг гаргахгүй бол бас энэ ариун цэвэр, нийгмийн эрүүл мэндийн асуудалд сөргөөр нөлөөлж байна гээд энэ Улаанбаатар хот доторх энэ цэвэрлэх байгууламжийн асуудлыг шинэчлэх ажил явагдаж байгааг та бүхэн мэдэж байгаа. Бас тэр бодлогын хүрээнд нийслэл хотоос энэ бохир, химийн элемент их ашигладаг, нөгөө талаас хог хаягдал ихтэй энэ үйлдвэрүүдийг гаргах энэ бодлогын хүрээнд Эмээлтийг сонгоод ТЭЗҮ-үүд нь, судалгаанууд нь хийгдээд явж байгаа ажил.

Дорнод бол манай хөдөө аж ахуйн гол ирээдүйн нөөц нутаг. Тэнд ашиглагдаагүй бид нар 500 гаран мянган га-д улсын тусгай хэрэгцээт газар байгаа. Тэнд маш том тэжээлийн, таримлын газар тариалангийн их ирээдүйн том нөөцийг хүн ам өссөн үед хэрэглэх ёстой. Тэрийгээ дагаад бас Дорнод өөрөө нөгөө талаасаа усаа дагаж байгаа. Дорнод гэсэн энэ үндсэндээ 4 гол байрлал.

Говьсүмбэр мөн адилхан төмөр зам, авто замынхаа уулзвар дээр нөгөө талаас говийн бүсийн тэр уул уурхайн олон энэ паркуудыг дагалдуулж сонгогдсон газар. Бас л нөгөө дэд усны гол судалгаан дээр суурилж хийж байгаа. Говьсүмбэр харьцангуй усан хангамж бололцоотой гэж гарсан байна лээ.

С.Ганбаатар: Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Ойлголоо. Ер нь Аж үйлдвэрийн, эрдэс баялгийнх нь яам болохоороо уурхай, үйлдвэрийгээ дагаад мэдээж хөнгөн үйлдвэрүүд нь болохоороо бусад олон зүйлүүдийгээ, дэд бүтэц, тэр зам, эх үүсвэр бүх зүйлүүдтэйгээ холбоотой байх. Гэхдээ та нөгөө хангайн 3 аймагт Баянхонгор, Архангай, Өвөрхангайд одоохондоо яагаад төлөвлөгдөөгүй байгаа дээр хариулт өгөөрэй Энхбаяр сайд. Яг тэр 3 аймаг дээр байхгүй байна лээ.

Тэгээд өнөөдөр яах вэ манай Аж үйлдвэржилтийн байнгын хороо болохоороо дандаа энэ хуулийг яг батлуулсан. Аж үйлдвэржилтийн паркийн энэ эрх зүйн байдлын тухай хуулийг батлуулсан төрийнхөнтэйгөө уулзаж байна шүү дээ. Тэгээд магадгүй яг энэ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр баталсан 12 байршилтай холбоотой яг энэ хуулийг хэрэгжүүлж байгаа тэр хувийн хэвшил, тэр яг хэрэгжүүлээд ажиллаж байгаа хүмүүстэйгээ бүгдээрээ бас уулзах ёстой байх гэж бодож байна. Тэгээд тэр дээрээс л хуулийн яг тийм асуудлууд нь гарч ирэх байх. Одоогийн байдлаар журмууд хэтэрхий данхар байна л гээд байгаа. Энэ дээр бүгдээрээ ажиллана.

С.Ганбаатар: 4 номерын микрофонд Ж.Энхбаяр сайд хариулна.

Ж.Энхбаяр: Хангайн бүсэд үйлдвэржилтийн томоохон юм төлөх бололцоо байхгүй байгаа шалтгаан нь эрчим хүчний дутагдал. Ховд бол Эрдэнэбүрээний том УЦС орно. Эрчим хүчний эх үүсвэрээ хангах бололцоо тэнд түрүүлж бүрдэж байгаа.

Дархан бол ОХУ-аас импортоор орж ирдэг гол шугам дээр сууж байгаа. Тэгэхээрээ бололцоотой.

Дорнод өөрийн цахилгаан станцтай. Дулааны болон цахилгаан станцтай. Сая өргөтгөлөөр хийгдчихсэн.

Говьсүмбэр болохоор гол нөгөө магистрал зам дээр сууж байгаа. Дэд бүтэц, эрчим хүчнийхээ эх үүсвэр, ус, тэгээд хүний ажиллах хүчний нөөц гэдгээр тулгуурлаж байгаа. Хүний нөөц хүрэлцэхгүй болж байгаа. Тэгэхээр Аж үйлдвэржилтийн байнгын хороо цаашид энэ салбарт ажиллах боловсон хүчний асуудлыг, гадаадаас ажиллах хүч авах асуудал дээр нэг мөр шийд гаргах дээр бас санаачилга гарвал хэрэгтэй байгаа. Ер нь хөдөө аж ахуйн салбар тэр, хөнгөн үйлдвэрийн салбар тэр ч.../минут дуусав./

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр бид өнөөдөр хөнгөн үйлдвэр, хүнсний үйлдвэр, аж үйлдвэржилт, хүнд үйлдвэрийн бодлогын асуудлыг яриад татварыг хэдэн жилээр чөлөөлж байгаа, хойшлуулж байгаа тухай яриад сууж байгаа нь их сайхан байна. Ердөө 12-хон жилийн өмнө Монгол Улсад аж үйлдвэрийн парк байгуулъя, Дарханд арьс ширний үйлдвэр байгуулъя, Монгол Улсад үйлдвэр барьж байгуулъя гэхэд улсаараа дооглож шоолдог, доромжилдог, бүр шоронд аваачаад хийчихдэг цаг үе ард хоцорсон байгаад бас их талархаж байна. Энэ дээр монголчуудын аж үйлдвэржилтийн бодлого ялж байгаа юм байна, ялсаар яваа юм байна.

Тэгэхдээ сайн юманд садаа мундахгүй байна. Бас дахиад л энэ бодлогын эсрэг төр нь өөрөө бодлогоо гаргадаг, дахиад л ямар нэгэн хууль, дүрэм хэлэлцээрээрээ нөгөө бодлогоо яллагчид саад, тээг хийдэг ийм байдал байсаар байна. Жишээ нь Евро-Азийн эдийн засгийн холбоотой хийх гэж байгаа Чөлөөт худалдааны хэлэлцээрийн талаар Энхбаяр сайдаас болон бусад хүмүүсийн бодлыг асууя гэж бодож байна л даа. Энд манай хүнсчид хөнгөн үйлдвэрийнхэн сав, баглаа боодол үйлдвэрийн төлөөллүүд хаа сайгүй гомдол гаргаад л яваад байгаа. Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн гэхэд л 1.8 их наядын санхүүжилттэй, 800 гаруй тэрбумын зээл өгчихсөн байгаа. Энэ жижиг хөл дээрээ тогтож ядаж байгаа үйлдвэрүүд чинь уналаа, импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөх чадамжгүй боллоо, ЖДҮ-чид бүүр баларлаа гэдэг ийм гомдлыг тавиад л байгаа.

Тэгэхээр энэ хэлэлцээрт гол нэрийн хүнсний 19 бүтээгдэхүүн байна. Дээрээс нь дөнгөж хөл дээрээ тогтож байгаа импортыг орлох гэж ядаж байгаа үйлдвэрлэгч нараа яаж аврах юм бэ? Энэ талаар та нараас санал авсан уу? Аж ахуйн нэгжүүдтэй уулзсан уу? Энэ хэлэлцээрт ямар байр суурь баримталж, бодлого баримталж орох гэж байгаа вэ гэдэг асуултыг асууя.

С.Ганбаатар: 4 номерын микрофонд Ж.Энхбаяр сайд хариулна.

Ж.Энхбаяр: Евро-Ази эдийн засаг засгийн холбоотой 2 талын түр гэрээ хийх асуудал Эдийн засаг, хөгжлийн яам хариуцан ажиллаж байгаа. Энэ нийт 375 төрлийн бараа харилцан татвар болон квотын хөнгөлөлттэйгөөр 2 талаасаа худалдаа явагдана. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бодлого бол дотооддоо үйлдвэрлэх бололцоотой, ялангуяа Хүнсний хувьсгал хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт авсан нийт 19 нэр төрлийн 40 орчим багц барааг энэ гэрээний 375 нэр төрлөөс хасах саналтай байгаа. Энэ талаараа учир шалтгааныг тайлбарлаж Хөгжлийн яаманд материал, тайлангуудыг хүргүүлсэн.

Учир шалтгаан нь юу вэ гэвэл өнгөрсөн үед болсон КОВИД, цар тахлын сургамж, бүх хил, гааль, боомт хаагдсан. Хэрвээ ахиад 1 сараар хугацаа алдаад КОВИД вакцинжуулалт хийгдэлгүй сунжирсан нөхцөлд Монгол Улс хүнсээ картаар олгохоос аргагүй ийм хүнсний аюулгүй байдалд туйлын ноцтой сул байгаа нь тодорхой байгаа, болсон. Иймд энэ 40 орчим нэр төрлийн 19 багц энэ барааг ямар ч үнээр хамаагүй эх орондоо тарьдаг, ургуулдаг, үйлдвэрлэдэг байх нь улс орны аюулгүй байдалд онцгой чухал гэж шийдвэр гарч энэ бодлого хэрэгжиж байгаа.

Нөгөө талаас сайн тал бас энэ гэрээ хийгдсэн нөхцөлд манай хөнгөн үйлдвэрийн салбарт арьс шир, ноос ноолуурынх нь экспортын их том боломж олдоно. Тэгэхээр бүх юм 2 талтай байгаа. Хүнсний салбар дээрээ бид квотоо, хязгаарлалтаа энэ жагсаалтаа хасаад хөнгөн үйлдвэрийн салбараа эндээ түлхүү оруулаад явбал Монгол Улсын эдийн засагт бас ач холбогдолтой. Энийг нэг талд нь туйлширч, үгүйсгэж ерөөсөө болохгүй. Аль аль талдаа.

Тэгэхээр энэ чинь хэлэлцээр тийм болохоор нэр төрөл болгон дээр хэлэлцээр явагддаг. Иймд хүнснийхээ гол бараан дээрээ бид нар яагаад ч буулт хийж болохгүй. Энэ бол маш их сөрөг тусгал гэж ийм байр сууриа илэрхийлээд байж байгаа.

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Тэр 375 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн гэж байна шүү дээ. Тэндээсээ манай Хүнсчдийн холбоо, Газар тариалан эрхлэгчдийн холбоо, Хүнсний хувьсгал ТББ-аас гаргасан тэр хүсэлтийг харсан, 100 нэр төрлийн барааг хасаж өгөөч гэсэн байсан. Тэгэхээр тухайн холбооноос хэчнээн нэр төрлийн бараа Монгол руу орж ирэх юм? Монголоос хэчнээн нэр төрлийн бараа гадагшаа гарах гэж байгаа юм? Энэ нь яг аль аль салбарт харьяалагдаж байгаа вэ гэдэг дээр танай яаманд мэдээлэл байгаа юу? Энэ дээр хариулт өгөх үү.

С.Ганбаатар: Энэ дээр тодруулж хариулъя. 4 номерын микрофон Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Харилцан 375 нэр төрлийн бараа. Тэнцүү ер нь хоёр талын юм чинь тэнцүү. Тэгээд л энэ дотор манай хүнсний бүтээгдэхүүний тоо нэлээн өндөр байгаа. Тэгээд бид бол 40 гаруй яг энэ Хүнсний хувьсгалаас санхүүжээд босоод ирсэн, дотооддоо бүрэн хангаж чадаж байгаа энэ бараануудаа хамгаалах ёстой гэж бодож байгаа. Хамгаалах ийм байр суурьтай байгаа. Энэ нэр төрлийг гэрээнээс хасъя. Бусад нь хангалт дутуу, өндөр үнэтэй, дотоод өрсөлдөх чадвар

сул ийм зүйлээ импортоор аваад явах нь хэрэглээний олон төрөл бий болно, иргэдэд их таатай нөлөөлнө гэж үзэж байгаа.

Арьс шир, ноос ноолуурын салбар, махныханд их сайн бололцоо олдоно. Экспортын нэлээн том 200 сая хүний зах зээл нээгдэх юм байгаа юм. Гол бидний сургамж буюу КОВИД-оос авсан сургамж хүнс их чухал. Хүнсээ л дотооддоо энэ цөөн нэр төрлийн.../минут дуусав./

С.Ганбаатар: Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгаланд төрлөөр нь, тэр хүнсний үйлдвэрлэлийн салбараар нь, тоо баримттай, судалгаатай нь тун даруйхан явуулаарай.

Золжаргал Улсын Их Хурлын гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Баярлалаа. Аж үйлдвэрийн парк мэдээж яах вэ том төвлөрсөн үйлдвэртээ бол хэрэгтэй байна. Манай Монгол Улс чинь талаар нэг тархсан тийм нүүдэлчин ахуйтай хүмүүс. Ийм сүүн бүтээгдэхүүн дээр хэдэн хувийг нь гэдэг билээ дээ, дийлэнх нь сүүгээ гаднаас авдаг юм байна лээ шүү дээ хуурай сүү. Тэгээд бид нар масло Европоос авч байгаа, торт дээр хийдэг кремийг Америкаас авч байгаа гэх мэтчилэн байдаг. Нөгөө технологи нь болохоор үйлдвэрийн парксаад байх юм байхгүй ахуйн түвшний жижиг тоног төхөөрөмжтэй ажилладаг тэр нь хөргөгчтэй ч болчихсон ийм боломжтой.

Тэгэхээр сүүг бол манай энэ Хэнтийнхэн ялангуяа их хийдэг шүү дээ. Нөгөө цөцгий гаргаад авчихдаг машиндаад, дараа нь цөцгийгөөсөө дахиад масло болгочихно. Маслоо хайрцаглаад хөлдөөгчид хийчих юм бол тэгээд сүү шиг гашлаад байхгүй тун болохоор хэлэхэд. Гаргасан сүүгээ дахиад ээдэм болгочихдог, шар сүүг нь бол тэр шар сүүн дээр л нэлээн том тоног төхөөрөмж хэрэгтэй юм байна лээ. Шүүнгүүтээ нөгөө бодибилдингийн уураг гаргаж аваад ихэнх нь үлдсэн нь ус.

Тэгэхээр тийм юмыг ахуйн түвшинд, эсвэл саахалт айлын түвшинд хийдэг уламжлалт технологи дэлхийгээр байна. Энийг Монголдоо нутагшуулах ийм ахуйн инновацыг нэвтрүүлэх тал дээр Хөдөө аж ахуйн яам маань ямар бодолтой байдаг юм болоо? Энэ талаар 1 асуулт байна.

Хүнд үйлдвэрлэлийнхнээсээ асуух асуулт байна. Алтанширээтийн хөрөнгө оруулалтын дэд бүтцийн хөрөнгө оруулалт байсан. Тэгээд тэр нөгөө газрын тосны үйлдвэр дотроо тооцогдож явдаг юм уу, эсвэл тусдаа энэ үйлдвэрийн паркийн хөрөнгө оруулалт гэж явдаг юм болов уу гэж 1 асуулт.

Хоёрдугаарт, одоо энэ том үйлдвэрийн дэд бүтцийг чинь төсвийн хөрөнгөөр барьж өгч байгаа. Цаана нь ингээд талбай дотроо энэ хуулиараа өрсөлдөөнд саад болохгүй нээлттэй ийм байх ёстой ерөнхий зарчим нь. Тэгэхээр тэнд орж байгаа хөрөнгө оруулагч нар нь ямар байдлаар, одоо яг ямар ямар хөрөнгө оруулагч байгаа вэ хэрэгжиж байгаа төслүүд дээр? Нэмж тийшээ хүн орохын тулд яах ёстой вэ гэдэг дээр мэдээлэл өгөөч. Тэр нь нээлттэй юу? Өөрөөр хэлбэл, төсвийн мөнгөөр 1 хөрөнгө оруулагчийн төлөө юм хийнэ гэдэг бол зохисгүй. Эс үгүй бол тэрэнтэйгээ хөрөнгө оруулалтын гэрээ байдаг юм уу?

Дараагийн асуулт нь болохоор дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг аж үйлдвэрийн паркийн үйл ажиллагаанаас хэзээ нэгэн цагт үйлчилгээ үзүүлэх

замаар буцааж авч, төсөвт төвлөрүүлнэ гэсэн тийм юм байна уу, үгүй юү? Эсвэл зүгээр үйлдвэрлэлийг хөгжүүлэх ёстой учраас угаасаа л гарах ёстой зардал гээд 1 удаа гаргаад дуусгах уу? Ийм зарчмын асуулт байна.

АМНАТ, түүхий эдээ худалдаж авахдаа дотоодод борлуулж байгаа гэдгээр багасгасан АМНАТ төлчхөөд дараа нь бүтээгдэхүүнээ экспортлоход АМНАТ төлөөд, хурдан төлснийгөө хасаад, багасгаж төлөх ийм зохицуулалт хууль дээр байгаа тээ? Тэрийг хэрэгжихгүй байна гээд үйлдвэрийнхэн дандаа л зовлон яриад байдаг. Энэ одоо ямархуу байдалтай байгаа бол энэ талаар мэдээлэл өгнө үү. Давхар АМНАТ аваад байна, үйлдвэр хөгжихгүй байна гэдэг шүү дээ.

Тэгээд 1 асуулт байна. Энэ Эрдэнэс аж үйлдвэрийн парк компани энэ компани аж үйлдвэрийн паркийн удирдлагыг хэрэгжүүлэгч компани уу, эсвэл аж үйлдвэрийн паркийн нэгж үү? Гол нь бас Эрдэнэс Монголын нэгдлийн хүрээнд байгаа төслүүдийг менеж хийж байгаа. Тэгэхээр одоогийн байдлаар хэчнээн хэмжээний мөнгө зараад, ямар хэмжээний ажил хийсэн юм, ямар бүтэцтэй байдаг юм болоо? Баярлалаа.

С.Ганбаатар: Асуултад хариулъя. 4 номерын микрофонд Ж.Энхбаяр сайд хариулна. Дараа нь 5 номерын микрофонд Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга хариулна.

Ж.Энхбаяр: Энэ сая сүүн дээр жишээ хэллээ. Үнэхээр нүүдлийн мал аж ахуйгаас хүн амын энэ сүүний хэрэгцээг хангах боломжгүй нь сүүлийн 30 жил хангалттай нотлогдлоо. Хүн амын дийлэнх нь төв суурин газар төвлөрсөн. Энийг 60, 70 сая маллах, дэлэнгээр нь тооцоод сүүний нөөц байна гэж үзээд байдаг боловч нүүдлийн мал аж ахуйгаар төв суурин газрыг хангаж болохгүй юм байна. Боломжгүй байна. Асар их өндөр өртөг зардалтай ч болох юм байна.

Тэгэхээр зайлшгүй энэ ялангуяа сүүний аж ахуйг 100 хувь эрчимжүүлэх, байран маллагаатай 365 хоногийн саалийн горимтой ашиг шимт сүүний үйлдвэрийн үхэр сүргийг нэмэгдүүлж, түүнээсээ үйлдвэрүүдээ түүхий эдээр хангах, тэгээд энэ ариун цэвэр стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх ёстой юм байна гэдэг нь тодорхой. Энэ чиглэлээр яам бүх бодлогоо яг энд чиглүүлж байгаа. Жишээлбэл, хуурай сүү гэхэд үндсэндээ 100 хувь импорт, цөцгийн тос үндсэндээ импорт. Тэгээд л мөхөөлдөс, таргаас авхуулаад л ер нь Монгол Улс нийт сүү, сүүн бүтээгдэхүүний бараг 60 гаруй хувийг импортоор авч байгаа. Энд олон зуун, тэрбум төгрөгийг зарж байгаа.

Тэгэхээр сүүний салбарыг кластераар хөгжүүлэхийн тулд Төвийн бүс буюу газар тариалан дээрээ тулгуурласан, тэжээлийн бааз дээрээ тулгуурласан эрчимжсэн ийм аж ахуйнуудыг олон арваар байгуулж байж шийдэх юм байна гэдэг нь тодорхой болсон байгаа.

Мэдээж уламжлалт нүүдлийн соёл иргэншилд манайх энэ ард иргэд маань малаа саагаад, өрөм тосоо аваад, өөрсдөө энэ уламжлалт дотоод хэрэглээгээ, эргэн тойрноо хангаж байгаа. Хамгийн гол нь нийт төвлөрсөн хүн амын энэ хэрэглээг яг тийм маягаар хангах ямар нэгэн бололцоогүй байгаа.

Тэгэхээрээ энд бас зүгээр орхиж болохгүй энэ Шинэ хоршоо хөдөлгөөний чинь гол зорилт тэр л байгаа юм. 9 өрх нийлээд, хоршоод хөнгөлөлттэй урт хугацааны зээл өгөөд, түүгээрээ хадлан тэжээлээ авдаг, сүү, цагаан идээгээ

боловсруулдаг, түүхий эдээ боловсруулж бэлддэг тийм зохион байгуулалтаар явах ёстой гэдэг маань Шинэ хоршоо хөдөлгөөний минь гол зорилго нь тэр шүү дээ. Анхны түүхий эдийн бэлтгэлийг хийдэг, тэр малчдаа хоршоожуулъя, хөдөлмөрөөр нь нийлүүлбэ. Тэр хүрээнд нь олгосон зээлийн хүрээнд яг энэ чиглэлийн бас сайн сайн жишээнүүд олон бий болсон байна лээ. Хөөрхөн сүү боловсруулах юмнуудаа авсан байна, айраг исгэх чадавхуудаа нэмэгдүүлсэн байна, газар тариалан, тэжээл тарьдаг болсон байна, трактор комбанитай болсон байна гээд, худаг усаа янзалцагасан байна, ашиг шимт малынхаа тоог сайжруулсан байна гээд их сайн сайн жишээнүүд байгаа.

С.Ганбаатар: 5 номерт Жавхланбаатар дарга.

С.Жавхланбаатар: Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Алтанширээт үйлдвэрлэл, технологийн парк, газрын тос боловсруулах үйлдвэр хоёр тусдаа, салангид гэсэн үг. Тэр дотор холилдсон юм байхгүй. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд паркийн удирдлагын өмчлөлийн хэлбэрийг заагаад өгчихсөн байгаа. Төрийн өмчид байж болно, орон нутгийн өмчид байж болно, хувийн өмчид байж болно гээд, холилдсон хэлбэр бас байж болно бусад гээд.

Тэгэхээр аль ч ийм өмчлөлийн хэлбэртэй паркийн удирдлага байсан ч гэсэн баримтлах зарчим нь аливаа нөгөө өрсөлдөөнийг хаахгүй, хязгаарлахгүй, ашиг сонирхлоос ангид, ил тод, нээлттэй, тогтвортой байна гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл бусад хөрөнгө оруулагч нарт нээлттэй.

Нөгөө таны асуулт болохоор энэ Алтанширээт, Гэрэлт говь эд нар дээр улсын төсвөөс ямар хөрөнгө оруулалт байхгүй. Өөрөөр хэлбэл энэ хувийн нөгөө өмчит хэлбэртэй. Тэгэхдээ энэ паркуудад хөрөнгө оруулагч орох бусад төсөл хэрэгжих боломжтой гэсэн үг. Одоогоор бид нар Эрдэнэс УТП буюу Эрдэнэтийн төрийн өмчит үйлдвэрийн өөрийнх нь хөрөнгө оруулалттай дэд бүтэц татсан байгаа. Бусдыг нь төлөвлөж байгаад гэсэн үг.

Эрдэнэс УТП-ийн юуг танд жич авч өгье. Яагаад гэвэл Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам менежментэд ямар ч оролцоо байхгүй. Гаргасан хөрөнгө оруулалтыг бол Эрдэнэс Монгол хариуцдаг, удирдлагыг нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцаж байгаа. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар бас ордог байгаа.

АМНАТ-ын асуудал болохоор яг амьдрал дээр яг тооцохдоо энэ бас татварынхантай бид нар бас маргаантай байдаг. Энэ саяын таны хэлдэг хасалтыг бүрэн хийхгүй. Яагаад гэвэл нөгөө ангиллаа бас маш сайн нарийн ялгах ёстой болчихоод байгаа юм. Тэгээд валью адишн /value addition/буюу нөгөө нэмүү өртөг хийчихсэнийг, ангиллыг бас ялгаж, салгаж өгөхгүй болохоор зэрэг зэрэг яг адилхан бүтээгдэхүүн дээрээс ингэж тооцоо авах асуудлууд ингэж үүсээд байгаа. Энэ дээр бид нар ажиллаж байгаа. Баярлалаа.

С.Ганбаатар: Золжаргал гишүүн тодруулъя, тодруулж асууя.

Ж.Золжаргал: Жавхлан даргын юун дээр дэд бүтцийн хөрөнгийг төсвөөс хийж байгаа тээ аж үйлдвэрийн? Үгүй юм уу? Алтанширээтийн, аан зөв.

Алтанширээтийн тэр төмөр зам юуны юу чинь газрын тосны төсөл рүү ирсэн төмөр замаас тусдаа дахиад параллель төмөр зам юм уу? Энэ мэдээллийг тэгвэл аваагүй хоцорсон юм байна.

Энхбаяр сайдад би ийм зүйлд бас анхаарлаа хандуулаасай л гэж хүсэж байна. Тэртээ тэргүй нүүдлийн ахуй байдгаараа байна. Нөгөө сүү боловсруулах гарын доор жижиг хэмжээний ахуйн технологиуд, тэгээд тэр тортны кремээс өгсүүлээд Германаас орж ирдэг масло энэ тэр чинь бүгд л ахуйн түвшинд хийгдэх, байж болохоор. Хатаалт горим нь шингэн сүүнээс арай өөр. Тэгээд тэр чиглэл.../минут дуусав./

С.Ганбаатар: Энхбаяр сайд 4 номерын микрофонд хариулъя.

Ж.Энхбаяр: Ойлголоо. Энэ хөдөө аж ахуй, мал аж ахуй дээр байгаа иргэдээ түүхий эдээ боловсруулахад шаардлагатай орчин үеийн авсаархан, сэргээгдэх эрчим хүч ашигладаг, овор багатай ийм хөөрхөн бүтээгдэхүүн хийчих бололцоотой ийм төхөөрөмжүүдийг нийлүүлэлт, сурталчилгаа, сургалтыг нэлээн анхаар гэсэн ийм санал байна. Ойлголоо.

С.Ганбаатар: Далайн Батбаяр гишүүн асуулт асууя.

Д.Батбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд 2019 оноос хойш манайхан Дархан дээр арьс ширний үйлдвэр барих гэж их оролдсон. Манай төр өөрсдөө улс санхүүжүүлээд барих гэж оролдлоо. Харамсалтай нь өдий хүртэл бүтсэн, болсон зүйл байдаггүй. Төсөл гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүдтэй гэрээг нь байгуулаад 18 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг нь Хөгжлийн банкнаас гаргаж өгсөн. Одоо нөгөөх нь хүүтэйгээ, алдангитайгаа нийлээд 34 тэрбум төгрөг болчихсон. Нөгөө гэрээ байгуулсан аж ахуйн нэгж нь 40 гаруй тэрбум төгрөг бид нарт зарцуулчихсан гэж яриад байдаг. Одоогоор нүдэнд үзэгдэж, гарт баригдах ямар ч бүтээн байгуулалт байхгүй байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ төсөл хэрэгжээгүйд яг ямар дүгнэлт хийсэн бэ гэдэг ийм асуулт байна. Тухайд нь, жил бүрд нь санхүүжилт гарах үед нь санхүүгийн жил бүрд нь ямарваа нэгэн хяналт шалгалт ер нь хийж явсан юм болов уу? Хамаарч байгаа яаман дээр нь хүртэл хүмүүс нь байж л байгаа байх гэж бодож байна.

Тэгээд бүтсэн юм байхгүй, улсын банкны мөнгө байхгүй болоод дуусчихсан байгаад байгаа. Тэгээд энийг ахиад шинэчлээд цогцолборын бүтээн байгуулалт гээд бас аж ахуйн бас төслийн байгууллага бий болгочхоод дахиад шинээр эхэлж байна. Тэгэхээр энийг ер нь энэ төслийг бий болсных нь дараа хэн авч явах юм? Төр нь авч явах юм уу, яам нь авч явах юм уу гэдэг дээр ийм гаргасан шийдэл байна уу? Үйлдвэр босдог юм байж. Үйлдвэр бослоо гэхэд энэ түүхий эдийг ер нь хэр их хэмжээний түүхий эд цуглана гэсэн тооцоо байгаа вэ? Яаж цуглуулна гэсэн судалгаа байгаа вэ, төлөвлөгөө байгаа вэ гэдэг асуулт байна. Энийг яах вэ ахиад энийг хөнгөн аж үйлдвэрийн цогцолбор гэдгийн хүрээнд бас байгуулъя гэж ярьсан.

Тэгээд нэлээн их хэмжээний үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулах гэж оролдсон байна. Хэдэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах гэж оролдсон байна, хэд нь тодорхой, хэдэнд ер нь амжилт олчихсон юм? Хамгийн гол нь би бодлогын л юм асуугаадахъя. Яах вэ урд нь бид нар ийм алдаа гаргажээ, үүнээсээ бид нар ингээд суралцсан, энэ удаа арай өөрөөр ингэж хийнэ ээ гэдэг ийм шинэ

санааг л сонсох гээд байгаа. Сайдаас нь бас онцлоод асуучихмаар байгаад байгаа юм. Энэ 3 жилийн хугацаанд энэ арьс ширний үйлдвэр ашиглалтад орох уу? Та амлах уу гэдэг асуулт байна.

Хоёрдугаарт нь Аж үйлдвэрийн Төрийн нарийн бичгийн даргаас асууя. Та харж байгаа байх бид нар үйлдвэр барих гэж иймэрхүү байдлаар ажилладаг. Үйлдвэр барьсан нь, ашиглалтад орсон иймэрхүү байгаа. Тэгэхээр таны ярьж байгаа 2026, 27, 28 онуудад ашиглалтад орноо гээд их сайхан сайхан үйлдвэрийн нэрс гарч байна.

Тэгэхээр энэ дээр бодлогын ямар шийдвэр байгаа вэ? Та нар энийгээ өөрсдөө ашиглаад явах юм уу? Энийгээ өөрсдөө цааш нь хариуцаад явах юм уу? Хаанахын зардлаар хэн нь бариад байгаа юм бэ? Танай яам бариад байгаа юм уу, эсвэл аж ахуйн нэгжүүд нь бариад байгаа юм уу? Тэд нар өөрсдөө хөрөнгөө оруулчихсан юм уу? Ер нь төр нь бизнесээ хийгээд явах юм уу, эсвэл бизнесийн байгууллагуудын хийгээд байгаа ажлыг та нар энд ажил гэж яриад байна уу? Яагаад гэхээр миний бас ийм бодол байгаад байдаг юм л даа. Дөнгөж саяхан ч гэсэн сонсож байсан Бөөрөлжүүтийн цахилгаан станц дээр жишээлбэл 400 орчим хүн ажиллана гэж байх жишээтэй. Яг адилхан хүчин чадалтай энэ 3 дугаар цахилгаан станцаар 1000 гаруй хүн ажиллаж байх жишээтэй. Тийм ч учраас төр өөрөө бизнес хийх нь үр ашиггүй ээ гэж боддог. Бизнесийн орчин нөхцөлийг нь бүр.../минут дуусав./

С.Ганбаатар: Асуултад хариулъя. 5 номерын Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга хариулна. Дараа нь 4 номер Ж.Энхбаяр сайд хариулна.

С.Жавхланбаатар: Батбаяр гишүүний асуултад хариулъя.

Ер нь бол бид нар бодлогоор л дэмжиж байгаа юм. Өөрөөр хэлбэл, одоогийн саяын амжилттай явж байгаа 2, Дорноговьд явж байгаа 2 үйлдвэрлэл, технологийн парк маань төрийн ямар ч оролцоо байхгүй. Харин бид нарын төрөөс баталсан, Их Хурлаас баталсан энэ үйлдвэрлэл, технологийн паркийн хуульд үзүүлсэн хөнгөлөлтүүдийг аваад бид ашигтай ажиллаж байна гэж хэлж байгаа.

Харин төрөөс сая Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон 6 парк яригдаж байгаа. Үүний нэг нь эхэлчихсэн явж байгаа. Өөрөөр хэлбэл Эрдэнэт үйлдвэр өөрийн төсвийн хөрөнгөөрөө дэд бүтцүүддээ барьсан технологийн парк байгаа. Харин тэр парк дотор орж ирэх зэс баяжуулах үйлдвэр дээр бид нар төрийн өмчийн оролцооны асуудал яриагүй. Хөрөнгө оруулалтын хэлбэр, гадаадын хөрөнгө оруулагч, технологийн санхүүжилтийнхээ хэлбэрээс хамаарч шийдэгдэнэ. Тэгэхдээ яамны зүгээс бол бид нар аль болох төрийн өмчийн оролцоогүй өөрийн бизнес план дээрээ суурилсан ийм үйлдвэрүүдийг дэмжинэ. Гагцхүү Эрдэнэт өөрийнхөө гаргасан, дэд бүтцэд гаргасан тэр хөрөнгөө тэр дотор орж ирсэн хөрөнгө оруулагч нараас аль болох богино хугацаанд нөхөж авна гэсэн ийм бодлоготой ажиллаж байгаа.

С.Ганбаатар: 4 номерын микрофоныг нээж өгье.

Ж.Энхбаяр: Ер нь Монгол Улс жилдээ 17-18 сая ширхэг ширхэг арьс шир, нэхий, 30 мянган тонн хонины ноос, 8-10 мянган тонн ноолуур, 2 мянга орчим тонн тэмээний ноос, 240 тонн сарлагийн хөөвөр гэсэн гол түүхий эд байгаа. Үүнийхээ боловсруулалтын түвшнийг нэлээн дээшлүүлэхийн тулд Цагаан алт хөтөлбөр

гаргаж эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийг ахиухан олгохоор сая Улсын Их Хурал дээр төсөв батлагдсан.

Дарханы тухайд. Хувийн хэвшил Дархан-Уул аймагтай хамтраад Дархан арьс шир гэсэн энэ цогцолбор байгуулахаар ажил эхлээд хэдэн жил явсан. Хамгийн сүүлийн мэдээгээр Үндэсний аудитын газар хянан баталгаажуулалт, шалгалт хийгээд 40.8 тэрбум төгрөгийн дэд бүтцийн ажил хийсэн байна гэсэн ийм аудитын дүгнэлт гарсан байна.

Төсөл хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, санхүүгийн асуудал нь хүнд буюу Хөгжлийн банкин дээр зээлийн хугацаа хэтрэлтийн асуудал үүсээд үндсэндээ төсөл зогсчихсон байгаа. Энэ нь Дархан-Уул аймагтай хамтарсан орон нутгийн өмчид хувийн хэвшлийн хамтарсан ийм төсөл. Энэ ажилтай холбоотойгоор өмнөх Хүнс, хөдөө аж ахуйн яам Засгийн газраар асуудал оруулаад тусдаа ер нь энэ арьс ширний боловсруулах энэ үйлдвэрийн асуудлыг урагшлуулъя гээд дахин УҮГ-ыг байгуулаад ажил төлөвлөөд ТЭЗҮ, зураг төсөл, дэд бүтцийн зөвшөөрөл газрын асуудал шийдэгдээд ингээд ажил явж байгаа. Энэ жил сая анх удаа улсын төсөв дээр 7.1 тэрбум төгрөгийн зардал суусан.

Зөвхөн арьс шир гэх нь их явцуу юм гэж, явцуу байгаа нь тодорхой болсон. Яагаад гэвэл зөвхөн арьс ширний өөрөө технологийн цэвэрлэх байгууламж гэдэг нь өөр бусад үйлдвэрийн технологиудтайгаа. Бид арай өргөн хүрээнд хараад ер нь Дарханы хөнгөн үйлдвэрийн парк гэдгээрээ хийе. Энд арьс шир нь ч байг, ноос ноолуур нь ч байг, ээрмэл, сүлжмэл, оёмол ямар л хөнгөн үйлдвэрийн чиглэлийн ямар ч хөрөнгө оруулалт хийх бололцоотой байлгая. Хамгийн үнэтэй тэр суурь дэд бүтцэд нь бид нар улсын төсвөөр ажлыг нь урагшлуулаад өгье гэсэн л бодолтой хэрэгжүүлэх гээд явж байна. Зөвхөн арьс шир гэж явцуурах нь бас тийм таатай биш. Ховд бол яг арьс ширээр төрөлжиж байгаа. Эмээлт арьс ширээр төрөлжиж байгаа. Дарханы энэ хувийн хэвшил арьс шир дээр яг төрөлжиж байгаа. Иймд бидний хийх энэ хөнгөн хүнсний үйлдвэрийн технологийн парк гэдгээ бид нар олон төрөлтөөр болгож хийх нь зүйтэй гэсэн ийм бодолтой яваа.

Тэгэхээрээ тэр Дарханы арьс ширний хувийн хэвшлийн тэр төсөл рүү уулзалт хийсэн 2 хувилбар байгаа. Хувийн хэвшлийнхэн нь энэ оруулсан хөрөнгөө үнэлээд төрд өгье гэдэг хувилбар. Нөгөө арилжааны нөгөө Хөгжлийн банкны зээлтэйгээ тооцоод тийм санал бас тавьсан.

Нэг бол бид нарт дэмжлэг үзүүлээч ээ хөрөнгө оруулалтын. Тэгвэл бид гүйцээгээд ажлаа явуулъя гэдэг ийм 2 хувилбар байгаа. Тэгэхээр би Аж үйлдвэрийнхээ байнгын хорооны гишүүдийг уриад байгаа нь Дархан хотод яг ажлын хэсэг гаргаж очоод, яг тэр 2 паркийн газар дээр нь очоод, аж ахуйн нэгжүүд нь танилцуулгаа хийгээд бид бас бодлогын шийдэл гаргах ёстой байгаа юм. Энэ хувийн хэвшлийн хийчихсэн тэр 40.8 тэрбум дээр хөрөнгө нэмээд гүйцээх үү, эсвэл хувийн хэвслээс нь тэр оруулсан хөрөнгийг нь олгоод төр ачааллаа өөрөө аваад явах уу гэдгээ бас шийдвэр зайлшгүй гаргах хэрэгтэй. Аж ахуйн нэгжтэйгээ бид А, Б гээд 2 хувилбараа бэлдээд танилцуулахад бэлэн болгоод л байж байгаа.

С.Ганбаатар: Далайн Батбаяр гишүүн тодруулъя.

Д.Батбаяр: Баярлалаа. Ер нь энэ төсөл 19 оноос хойш хэрэгжиж эхэлж байх хугацаанд танай яаман дээрээс ч юм уу, Дархан-Уул аймаг дээрээс хяналт тавьж байсан ийм юм байдаг юм уу? Хяналт тавьж байгаагүй бол тэр банкных нь ч

байдаг юм уу, эсвэл тэр Дархан-Уул аймагт чинь хариуцаж байсан улсууд нь, өөрсдөө хамтарч байсан юм бол хяналт тавьж байсан тийм юм байхгүй бол эд нарт хариуцлага тооцох талаар яамнаас ямар нэгэн үйлдэл хийсэн үү?

Хоёрдугаарт нь энэ 3 жилийн хугацаанд энэ төсөл ер нь хэр хугацаа хэр их юм хийгдэнэ гэж та харж байна вэ? Тэгээд бас энэ сонсож байснаар бол энэ төслийг хэрэгжүүлж байсан энэ аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудыг бас эрүүгийн хэрэг үүсгэж саатуулж байсан гэсэн иймэрхүү мэдээлэл гарч байсан. Энэ хэр үндэслэлтэй байсан юм, шийтгэчихсэн юм уу, юу болсон юм, тэгээд хаячихдаг юм уу? Ажил хэрэг хийж байсан улсуудыг нь аваад, хориод, төсөл нь гацаад банкин дээр зээл нь гацаад явчихдаг.../минут дуусав./

С.Ганбаатар: Тодруулж хариулъя.

Ж.Энхбаяр: Нэгдүгээрт, энэ хувийн компанийн хувийн санаачилгатай төсөл орон нутагтай хамтраад хийсэн ажил. Энэ яамны ажил биш. Улсын төсвийн хөрөнгө оруулалт ороогүй. Тэр хууль шүүхийн асуудал нь нөгөө Хөгжлийн банкны асуудал сонсгол хийсэн шүү дээ. Тэр хүрээнд Хөгжлийн банкны хүрээнд шалгагдсан асуудлууд байгаа юм байна лээ. Манай мэдээлэл 40.8 тэрбум төгрөгийн ажил хийгдсэн, аудитаар баталгаажсан, аудит албан бичгээ өгсөн ийм ажил хийгдсэн байна. Одоо тэр хөрөнгийг яах вэ гэдэг асуудал байгаа юм. Хувийн хэвшил өөрөө аваад явахад санхүүгийн дутагдалтай байдаг. Энд нь төсвөөр дэмжлэг үзүүлж дэд бүтцийг нь гүйцээх үү, эсвэл буцаа төр 100 хувь шилжүүлэн авах уу гэдэг нэг ийм асуудал.

Бидний тухайд энэ ярьж байгаа энэ жилийн төсөв батлагдсан төвийн бүс дэх хүнс, хөнгөн үйлдвэрийн парк бол 25 га дээр шинээр төлөвлөгдөж байгаа шинэ зураг төсөл, зөвшөөрөл авсан.../минут дуусав./

С.Ганбаатар: Жаргалсайхан гишүүн асуулт асууя.

Д.Жаргалсайхан: Энэ Хөдөө аж ахуйн яамнаас Энхбаяр сайдаас Евроазийн худалдааны гэрээнд яг боловсруулсан махан бүтээгдэхүүн гэж орсон уу, эс үгүй бол яг түүхээрээ махан бүтээгдэхүүн гээд орсон байгаа юу? Нэг дэх асуудал.

Хоёр дахь асуудал. Бид хэд энэ баахан бүсчилсэн арьс шир боловсруулах үйлдвэр, парк гээд яриад байгаа. Яг өнөөдөр арьсны яг боловсруулсан арьс яг хэдэн төгрөгтэй байгаа вэ? Жишээ нь зах зээлд Хятадад, Туркт хэдтэй байгаа вэ? Энэний мэдээлэл та хэдэд байна уу? Миний авч байгаа мэдээллээр бол арьс ширээ боловсруулах зардал нь 10 мянга болчихоод тэгээд л боловсруулахгүй байгаа асуудал шүү дээ. Тэгээд л хаягдаад байгаа асуудал шүү дээ. Тэрнээс бид нар боловсруулж чадахгүй байгаадаа хаягдаад байгаа юм биш шүү дээ. Тэгээд энэ дээр та хэд байр суурь ямар байна? Миний авч байгаа мэдээллээр тийм байгаа. Та ойлгосонгүй юу тээ. Арьс ширний үнэ боловсруулсан зах зээлийнх нь үнэ хэдтэй байгаа вэ? Судалгаа хийсэн үү? Миний авч байгаа мэдээллээр жишээ нь урд хөшөө Хэбэйд 10 мянган төгрөгтэй л байгаа шүү дээ. 200-300 Юанийн л үнэтэй байгаа шүү дээ. Боловсруулсан арьс шир.

Тэгээд ийм үнэгүй болчихсон учраас л бид нар энд өнөөдөр хаяад байгаа шүү дээ. Тэрнээс бид нар боловсруулж чадахгүй байгаадаа биш шүү дээ. Өнөөдөр бид нар боловсруулна гэж яриад байгаа тээ? Тэгэхээр энэ чинь

боловсруулчихсаны дараа ч гэсэн бид нар тэр бүтээгдэхүүн болгохгүй бол хаягдана шүү дээ бас. Энэ дээр ямар судалгаа хийж байгаа юм? Энэ тал дээр ямар арга хэмжээ авах гэж байгаа юм? Тэгэхэд өнөөдөр бид нар боловсруулж чадахгүй байгаадаа хаяад байгаа юм шиг л яриад байна шүү дээ. Бүх хариултууд тэгж явж байна. Асууж байгаа асуулт ч тэгж яваад байна шүү дээ. Тэгэхээр энэ өөр ойлголт шүү. Энийг дагасан миний бас ийм бодол байгаа. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл дээр ямар бодлого барьж байна вэ? Жишээ нь нэхийгээр ямар ямар бүтээгдэхүүн хийж байна вэ? Тэрийг яаж Монголд оруулж ирэх вэ, энэ дээр ямар бодлого барьж байна, ямар төлөвлөгөө байгаа юм бэ? Тэрнээс боловсруулах асуудал яриад байх юм. Энэ чинь өрөөсгөл юм яваад байна шүү.

Аж үйлдвэрийн парк гээд төслөө олон жил ярьсан. Сая 9 нэр төрлийн хөнгөлөлт байгаа гээд ярьж байна. Энэ бол хангалтгүй. Энэ хөнгөлөлтүүдийг бүгдийг нь мэдэж байгаа. Энэ төслүүд дээр бас судалгаан дээр нь ажиллаж байсан. Үнэхээр энэ дэлхийн томоохон энэ улс орнууд чинь ямар хөнгөлөлт үзүүлээд, ямар байдалтай татвараа чөлөөлөөд, ямар зээл, ямар ч хүүгүй зээл олгоод, тэр зээл нь хэдэн арван жилийн хугацаатай олгож байж энэ үйлдвэрүүд чинь том юу гэдэг юм, нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг чинь гаргаж дэлхийн зах зээл дээр өрсөлдөж байна шүү дээ.

Тэгэхэд бид нар дэргэд нь үнэхээр жоохон юм яриад сууж байгаа байхгүй юу. Тэгээд энэ судалгааг яг яаж хийдэг юм та хэд? Би бас л та хэдийн ярьж байгаа, манай хүмүүсийн асууж байгаа асуултаар харахад ерөөсөө л аргацаасан 10 жилийн өмнө ярьж байсан юмаа л яриад сууж байна яг үнэндээ. Энэ аж үйлдвэрийн парк бид нар 10 жилийн өмнө ярьж байсан. Яг л яг тэр яриа яг өнөөдөр яг л байж байна.

Тийм учраас ч нэг үйлдвэр баригдахгүй байгаа шүү дээ. Бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Яагаад бид нар үйлдвэр барих гээд байгаа учир, ач холбогдол чинь энэ импортыг орлох бүтээгдэхүүн, тэр тусмаа валютынхаа урсгалыг бас яаж алдчихгүй шиг валютынхаа нөөцийг бүрдүүлээд явж байгаа, тэр тусмаа уул уурхайн бүтээгдэхүүн чинь нийт экспортын 93 хувь нь шүү дээ. Тэгээд энийгээ жоохон боловсруулъя, яаж энэ дэлхийн энэ бүтээгдэхүүнүүдтэй өрсөлдөх вэ л гэдэг бодлого явж байгаа шүү дээ.

Тэгэхээр ийм ахиц дэвшил гарахгүй л зовлон газар гээд энэ газар чинь зүгээр жоохон асуудал шүү дээ. Яагаад энэ том хөрөнгө оруулалтаар том үйлдвэрүүд баригдахгүй байгаа гэдэг чинь энэ том Монгол Улсын бодлого, энэ том энэ зах зээл дээр өрсөлдөх өрсөлдөөний ийм талбар дээр л бид нар шал өөр юм гаргаж өгөх ёстой шүү дээ. Тэгээд ийм л юм яримаар байна л даа. Ийм л юм л та хэдээс би судалгаа шаардаж байна. Жишээ нь Хятадад тэгээд бүүр нэр төрлөөрөө банкууд байгуулагдсан байгаа шүү дээ. Хөдөө аж ахуйн банк, тариалангийн банк гээд. Тэгэхэд ийм хүүгүй зээл олгоод явж байгаа энэ зээлтэй бид нар яаж өрсөлдөх юм? Чадахгүй шүү дээ. Энэ тал дээр ямар бодлого байдаг юм, ямар судалгаа байдаг юм? Ийм нэг хэсэг.

С.Ганбаатар: 4 номерын микрофонд Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Үнэхээр дэлхийн улс орнууд, хүнсний үйлдвэрлэл, дотоодын хөнгөн үйлдвэрлэлээ дэмжихийн тулд урт хугацааны нэн хөнгөлөлттэй ийм бодлогын зээл маш сайн дэмжиж байгаа.

Нөгөө талаар тарифыг их том татварын орчноор хамгаалдаг. Бидний хувьд амаргүй байгааг бүгд л мэдэж байгаа. Үнэхээр үйлдвэр, ялангуяа хөдөө аж ахуйн дотроо арьс ширний, ноосны зах зээл ер нь дэлхий нийтээрээ эрэлт муу байгаад байгаа юм. Сүүлийн нөгөө нано материалууд гарчихсан, илүү хөнгөн шингэн ийм хувцас хунар өмсдөг болчихсон, арьс ширний ийм эдлэл, ноос эдлэл хэрэглээ их багасаад байгаа.

Гэхдээ бас орон зайнууд байгаа. Бид бас технологийн болон үйл ажиллагааны шинэчлэл хийх хэрэгтэй. Жоохон өртөг шингэсэн бүтээгдэхүүн хийхийн тулд технологийн шинэчлэл хийх хэрэгтэй. Технологийн шинэчлэл хийхэд хөнгөлөлттэй зээлүүд дутаад байдаг. Энэ судалгаа явсаар байгаад “Цагаан алт” гэдэг хөтөлбөр өнгөрсөн Их Хурлаар батлагдсан. Одоо энэ 25 оны 1 сарын 1-нээс эхлэх гэж байна. Бид сая Сангийн яамтайгаа, Монголбанктайгаа үндсэндээ салбарт олгогдох зээлийн бодлого, хүү дээрээ, татаас дээрээсээ тохирч гэрээ зурж байна. Одоо энд ирэх долоо хоногт арилжааны 8-10 банкт хамт санхүүжилтийнхээ гэрээг зурна. Манай арьс шир, ноос ноолуурын салбар маань “Цагаан алт” хөтөлбөр туссаны дагуу эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлээ авах эрх нь нээгдэнэ. Энд 9-10 хувийн татаас улсын төсвөөс өгөхөөр аж ахуйн нэгжүүд дээр төлөх нь 8 хувь орчим дунджаар, 8 хувийн зээлийн ачаалалтай байхаар сая Монголбанк мөнгөний бодлого юмандаа тааруулаад гаргалаа.

Тэгэхээр одоо арьс ширний, ноос ноолуурын, боловсруулалтын, эргэлтийн хөрөнгө болон зээл, хөрөнгө оруулалтын тоног төхөөрөмж шинэчлэлээ хийх гэж байгаа аж ахуйн нэгжүүдэд эрх нь нээгдэж нээгдэнэ. Одоо багтаад бид нар бүх гэрээ хэлэлцээрээ хийгээд шинэ оноос ажил эхэлнэ. Ийм 2 зүйл байгаа. Шинэ он гараад бид мөн сая Улсын Их Хурлаар батлагдсан төсвийн Атрын IV дүгээр аян явагдана. Хүнсний хувьсгал үндсэндээ хэрэгжээд 1.2 их наяд төгрөгийн санхүүжилт арилжааны банкаар дамжиж аж ахуйн нэгжүүд очсон. Маш бодитой, тодорхой сайн үр дүнгүүд гарсан. Хүнсний үйлдвэрлэл, хүнсний шинэ нэр төрлийн бараа бий болох талд. Одоо Атрын IV-өөрөө ахиж энийгээ дэмжсэн бодлого нь залгагдаад, Цагаан алтаараа энэ арьс шир, ноос боловсруулах салбарууд нь залгагдаад, Шинэ хоршоо төсөл дээрээ нөгөө түүхий эд бэлдэж байгаа малчдаа зохион байгуулалт нь хэлбэрт оруулаад үйлдвэрийнхээ түүхий эдийг бэлтгэдэг, авдаг, нийлүүлдэг тэрийгээ жоохон чанаржуулах, энэ дүрэм маань хоорондоо цогц залгагдаад залгагдаад ажиллавал ахиц дэвшил гарах байх.

Гэхдээ бас харамсмаар юм сая төсөв дээр энэ бодлого хэрэгжүүлэх ёстой 130 тэрбум төгрөг хасагдсан гэдэг маань 130 тэрбумаар 1.5 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээл энэ салбарт очих зээл тэр хэмжээнд бас танагдчихсан байгаа. Ер нь баталсан төсвөөр ер нь үйл ажиллагаа, сургалт, гадаад томилолт, олон зүйл эрс хумигдсан. Үндсэндээ гадаад зах зээлийг нээх ажил бол Хөдөө аж ахуйн яамны гол үүрэг.

Тэгэхэд манай гадаад томилолтын зардалгүй сууж байх жишээтэй. Бид олон улсын яг мал эмнэлэг, ургамал хамгааллын ажлуудтай, дэлхийн хүнсний байгууллагатай ажиллаж энэ зах зээлээ нээхэд гол гадаад харилцаа идэвхтэй явуулах ёстой гэх мэтийн бас нэг бодлого нөгөөгөө бас хайчилсан зүйлүүд байна.

С.Ганбаатар: Нэмж Энхбаяр сайд хариулъя. 4 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Боловсруулсан үхрийн ширний үнэ яг зах зээлийн үнэ өнөөдөр 128800 орчим төгрөгөөр боловсруулагдаад үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн

үнэлэгдэж байгаа. Ямаа 18150, нэхий 27000 буюу боловсруулалт хийж байна. Гэхдээ нийт бид нар шаардлагатай түүхий эдийнхээ 30 орчим хувь дээр боловсруулалт хийж байна.

Нөгөө талаас мал эмнэлгийн асуудал их чухал. Малын өвчин, малын хачиг хувалз, тэгээд шимэгчийн асуудал, мал эрүүлжүүлэх, мал эмнэлгийн төсөв зардлыг байнга танаж байгаа байдал өөрөө яг ийм байдал руу явуулаад байгаа юм. Нэг талдаа гадаад зах зээлийн эрэлт унаад байдаг, дотооддоо малын арьсны гэмтэл их өндөр гараад байдаг. Нийт үйлдвэрт ирж байгаа арьсны 20 хувь нь үйлдвэрлэлийн стандартыг хангаж байна гэж үйлдвэрлэгч хэлээд байна. Бусад нь шаардлага хангахгүй байна.

Нөгөө талаас сүүлийн 30 жил манай мал маань их давжаарсан байна. Бод 30-40 кг-ээр, бог 6-8 кг-аар давжаарсан.

С.Ганбаатар: Бямбацогт гишүүн асуулт асууя.

С.Бямбацогт: Энхбаяр сайд ерөнхийд нь бас ярьж байна. Тэгэхээр Үйлдвэр, технологийн паркийн хуулийг 22 онд бас миний бие бусад гишүүдийн хамт санаачлаад Их Хуралд өргөн барьж батлуулсан. Үйлдвэр барих гэж байгаа иргэддээ төр дэд бүтцийг нь цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, зам талбай, хашаа хороо энэ бүгдийг нь бас төрөөс барьж өгье. Үйлдвэр бариад борлуулалт явуулаад эхлэх юм бол аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 5 жил 100 хувь чөлөөлье, 10 жил 50 хувь чөлөөлье гээд тодорхой татварын хөнгөлөлтүүдийг өгөхөөр ингэж үйлдвэрлэгчдээ дэмжье гэж. Энэ хууль маань амьдрал дээр яг бодитой байдал дээрээ, бас бодит байдал дээрээ бас хэрэгжихгүй байгаад байна.

Тухайлах юм бол, Ховд аймагт бид 19 онд Үйлдвэр, технологийн парк барьж эхэлсэн. Өнөөдрийг хүртэл тэр арьс шир боловсруулах, цэвэрлэх байгууламж нь баригдаагүй. Наад талд нь цэвэрлэх байгууламж баригдсан. Асуудал нь шийдэгдээгүй. Энд арьс шир боловсруулах боломжгүй ээ, энэ бол ахуйн цэвэрлэх байгууламж болох ёстой ингэчихсэн. Энийг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах манайх Хөдөө аж ахуйн яам, хөнгөн үйлдвэрийн газар Дондогдорж ерөөсөө ажлаа хийдэггүй. Одоо сая Энхбаяр сайд Ховдод арьс шир боловсруулах үйлдвэр барьж байгаа, бүх юм бэлэн болж байгаа гэж ярьж байна. Бэлэн болоогүй. Нөгөө арьс ширний цэвэрлэх байхгүй байгаа шүү дээ одоо болтол. Энийгээ хэзээ хийх юм бэ? Бид асуудлыг шийдээд байдаг. Мэргэжлийн яам нь ажлаа хийдэггүй.

Хоёрдугаарт нь ийм байдалтай дутагдалтай. Дээрээс нь дахиад нөгөө баахан татварууд. Боловсруулах үйлдвэрүүдийг 1 хувийн татвартай болгоод 1 сарын 1-нээс хэрэгжээд эхэлж байгаа. Тэгтэл нөгөө аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 100 хувь чөлөөлөх, 50 хувь хөнгөлөх гэдэг асуудал чинь энд цохигдоод явах гэж байна. Тэгвэл бусад татвар, гаалийн татвар, нэмэгдсэн өртөг, хүн амын орлогын албан татвар эдгээрийг хөнгөлж байж энд үйлдвэр байгуулах бас дэмжлэг болно. Энэ дээр бас бодлогын дэмжлэг байхгүй байгаад байгаа юм. Энэ дээр бас манай хариуцсан сайд маань бас яаж анхаарах ёстой юм болоо? Энийг хариулж өгөөч.

Дараагийн асуудал нөгөө Шинэ хоршоо. Шинэ хоршооны мөнгө маань үндсэндээ малчид аваад импортын машин, мотоцикл болоод явчхаад байгаа юм. Уг нь үүгээр бид нар саалиа бэлдэхэд саваа бэлд гэж саалиа бэлдэх малчдыг арьс

шир, ноос ноолуур, малын гаралтай түүхий эдийнхээ анхан шатын боловсруулалт хийх, малаа эрүүлжүүлэх, малынхаа үүлдрийн угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх энэ рүү зарцуул гэсэн энэ рүү зарцуулдаггүй. Энийг яг энэ рүү нь яаж зарцуулах ийм ямар бодлого хийж хэрэгжүүлэх гэж байна вэ? Энийг хариулж өгөөч.

Дараад нь “Цагаан алт” хөтөлбөр бас Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилсан. Үйлдвэр барих гэж байгаа иргэдэд хөнгөлөлттэй зээл олгоно гээд тодорхой хүүгийн татаас өгөх гэж байгаа. Энэ маань дахиад Шинэ хоршоотойгоо адилхан аваад үйлдвэр, байрны зээл авчхаад дахиад машин тоног төхөөрөмж болоод нөгөө импортыг нэмэгдүүлдэг, валютын ханш үүсгэдэг ийм болчих вий дээ. Энэ дээр та бүхэн бас ямархуу хяналт тавьж ажиллах гэж байна вэ? Уул нь энэ 3 хөтөлбөр Үйлдвэр, технологийн паркийн хууль, Шинэ хоршооны тухай явуулж байгаа бодлого, хөтөлбөр, “Цагаан алт” хөтөлбөр энэ 3 хоорондоо уялдаад явах юм бол яах аргагүй малын гаралтай түүхий эд, энэ хөнгөн үйлдвэрийг босоход маш том дэм болно. Үйлдвэрлэлдгийг нэг хэсэг нь дэмжинэ, нэг хэсэг нь малчдыг, малын гаралтай түүхий эдээр саалийг нь дэмжинэ, савыг нь дэмжинэ, дээрээс нь үйлдвэрт хөнгөлөлттэй зээл олгогдоно. Ингээд уул нь иж бүрэн юмнууд хийгдчихээд байгаа юм л даа.

Гэтэл яг бодит байдал дээрээ араа шүд нь эвцэлдээд гэдэг юм уу ажил болж өгдөггүй. Налайхын Үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлтийн үйлдвэрлэл, технологийн парк гээд л ярьж байна энэ хөнгөн үйлдвэрийн паркууд. Яг үнэндээ бодитой хийж байгаа юм юу ч байхгүй. Төрөөс, төсвөөс 1 тийм төгрөг тавиагүй. Хуулиа бид нар батлаад, дэд бүтцийг нь тийм үү төрөөс хийж өгнө гэж байсан. Цахилгаан, дулаан, цэвэр, бохир гэсэн байхад ерөөсөө мөнгө тавигддаггүй, юу ч хийгддэггүй. Ингээд хэдэн жил болчихсон, дахиад л хэдэн жил болох гээд л байгаа байхгүй юу. Тэгээд энийг урьд нь явж ирсэн ийм тийм ужгирсан энэ асуудлыг Энхбаяр сайд маань нэлээн анхааралдаа аваад шийдчихмээр байх юм. Одоо наад нөхдүүд чинь сайн мэдэж байгаа таны хажууд сууж байгаа хүмүүс. Олон жил би хэрүүл хийж байгаа. Энийг яаж шийдэх вэ?

С.Ганбаатар: Асуудал руу зүрх сэтгэлээ өгч ингэж манлайлж орохоос өөр аргагүй байгаа юм. Асуудлуудад маш тодорхой хариулна гэж би бодож байна. 4 номерын микрофон Ж.Энхбаяр сайд хариулна.

Ж.Энхбаяр: Тантай санал нэг байна. Үнэхээр хууль сайн хууль. Хөнгөлөлт тодорхой, хийх ажил тодорхой хуульчилсан. Төсөв дээр гишүүд маань яг сая төсвийн бид 2, 3 хэлэлцүүлэг хийлээ шүү дээ. Хөрөнгө тавьж өгөхгүй болохоор ажил яаж явах вэ. Тэгээд цувуулаад байдаг, цувуулаад байдаг. Эхний хийсэн ажил гүйцээгүй байхад дараагийн технологи, техникийн хоцрогдол, шинэчлэлүүд нь яваад байдаг. Нэг мөр тавиад хурдан дуусга. Одоо Ховд 19 оноос хойш 6 дахь жилдээ явж байна. Эмээлт мөн адилхан олон жил яригдсан. Тэр төсөв шүү дээ. Ерөөсөө төсөв тавиад дэд бүтцийг нь тэр ямар дэд бүтэц байх ёстой юм бүгдийг нь тэр хууль дээр заагаад өгчихсөн.

Тэгэхээр тэр төсвийн асуудал дээр л ажил явахгүй байна даа. Өөр юу хэлэх вэ? Яамны зохион байгуулалт, үйл ажиллагааны тухайд анхааръя. Ховдод өөрийн биеэр очиж тэр газар усан дээр нь очиж яг үйлдвэрийн бодлого, түүхий эдийн тооцоо, бүх юмаа харъя. Шийдэх асуудал. Энэ жилийн төсөв дээр Ховдод нэлээн бас гүйцээсэн бараг хэд 10 хэдэн тэрбум билүү, 18 тэрбум тавигдаад нэлээн ажлууд нэлээн явах байх. Тэгээд хамгийн түрүүнд Ховдын энэ паркийн ажил

нэлээн ажилдаа орно. Тэгэхээр Ховддоо нэлээн ирэх жил анхаарал тавиад сайн ажиллаадахъя.

Ер нь төсөв тавивал нэг мөсөн тавиад, тавихгүй бол ерөөсөө цувалт тавих их дэмий. Үр ашиггүй, удаан, төсөв өртөг сунжирдаг, үнэтэй болдог ийм байдал байгаа. Тэгэхээр Байнгын хороо очиж бүх ер нь паркуудаа шалгаад, дүгнэлт гаргаад, тэгээд эртхэн шиг энэ хаврын чуулган гэхэд бид нар төсвийн хүрээнд мэдэгдэл, мөнгөний бодлого дээр эртхэн шиг өгөөд, саналаа өгөөд явж байхгүй бол яг л дараа жил бид нар бас ийм юм яриад л сууж байна. Ахиад 4, 5, 4, 5 тэрбум амсуулсан ажил эхэлжээ гэсэн маягтай л байх болов уу.

С.Ганбаатар: Тодруулах уу? Бямбацогт гишүүн тодруулъя.

С.Бямбацогт: Энэ үйлдвэр, технологийн паркууд нэлээн олон газар хийгдэж, хэрэгжиж байгаа ажлууд. Энэ ажлуудаас хамгийн амжилттай, хамгийн ахиц дэвшилтэй явж байгаа ажил Ховд аймгийн үйлдвэр, технологийн парк байгаа. Ирэх жил үндсэндээ тэр арьс шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжаас бусад бүх дэд бүтцийн ажлууд, цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, зам талбай, хашаа хороо энэ бүх юм дуусчихна. Мөн хувийн хэвшлийнхээ үйлдвэрээ бариад эхэлчихнэ.

Тэгээд нөгөө “Цагаан алт” хөтөлбөрөөс хөнгөлөлттэй зээлээ аваад, малчид нь Шинэ хоршооноосоо нөгөө малынхаа түүхий эдийг анхан шатны боловсруулалт хийдэг энэ ажлыг нь зохион байгуулаад өгчихвөл бас түүхий эдийн нийлүүлэлт нь бас бий болчих байх. Гадна, дотнын хөрөнгө оруулагчид нь хувийн хэвшил рүү нэлээн хандаж байгаа. Ганцхан дутагдаад байгаа асуудал нь тэр би хэлээд байна шүү дээ. Тэр малын арьс шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж нь ор тас хаягдчихлаа. Энийг манай Дондогдорж сайн мэдэж байх ёстой. Ерөөсөө хийдэггүй, анхаарал тавьдаггүй. Энийг анхаараад өгөөч ээ, энийг л шийдчихвэл бусад нь болчих гээд байгаа байхгүй юу. Тэгээд загвар болгоод хийчихвэл.../минут дуусав./

С.Ганбаатар: Бямбацогт гишүүнд нэмж асуулт асуух микрофон нээж өгье.

С.Бямбацогт: Тэгэхээр бусад аймгууд байхгүй байгаа юм чинь. Энийг нэлээн ахицтай явчихсан юмыг загвар, тэгээд жишиг болохуйц байдлаар Хөдөө аж ахуйн яам анхаарал тавиад, онцгой анхаараад бүх юм, дутуу юмнуудыг нь гүйцээгээд хийчих юм бол энэ сайн төсөл болчихвол яг үүнийг хуулбарлаад, санаа аваад бусад төслүүд дээрээ хэрэгжүүлээд явах, алдсан алдааг нь давтахгүй, амжилт, ололтыг нь нэвтрүүлээд явчих бололцоо байгаад байгаа юм л даа.

Тийм болохоор бас энэ төсөл дээр жоохон анхаарал тавиад өгөөч. Тэр жоохон ганц гацаж байгаа, дутаж байгаа ажлуудыг нь бас гүйцээх тал дээр бас анхаараад иж бүрэн хэрэгжих, ашиглалтад оруулах талд нь бас Хөдөө аж ахуйн яамыг анхаараад өгөөч ээ л гэж дахин дахин хүсээд байгаа. Тэр цахилгаан хангамжийн асуудал байгаа. Дээрээс нь тэр цэвэрлэх, арьс ширний цэвэрлэх байгууламж. Тэр хэл амтай явж байгаа тэр юу гэдэг юм тэр цэвэрлэх байгууламж биш, олон жил гацчихсан дахиад цэвэрлэх байгууламж хэрэгтэй байгаад байгаа шүү дээ. Дондогдорж дарга, хөнгөн үйлдвэр хариуцсан дарга сайн л мэдэх ёстой доо.

С.Ганбаатар: 2 номерын микрофондоо хариулт өгье.

М.Дондогдорж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилт зохицуулах газрын дарга Дондогдорж.

Ховд үйлдвэр, технологийн паркийн цэвэрлэх байгууламжийн асуудал 2019 онд “Саруул цамхаг” компани мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэх байгууламж барих тендерт ялж гэрээ байгуулаад 20 онд хүлээлгэж өгөхөөр гэрээ байгуулсан. 20 онд энэ цэвэрлэх байгууламжийг хүлээлгэж өгөөгүй. Хүлээлгэж өгөөгүй гол шалтгаан бол 2014 онд аймагт хүлээлгэж өгсөн байсан цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж нь ашиглалт, хамгаалалтын шаардлага хангаагүй муудсан байсан учраас энэ тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүй ээ гэсэн ийм дүгнэлт гарсан. Энэ асуудлаас болоод цэвэрлэх байгууламжийг өдий хүртэл хүлээлгэж өгөөгүй. 2024 онд энэ тоног төхөөрөмжийг, хуучин байсан тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүй учраас 2024 онд 1.9 тэрбум төгрөгийг энэ цэвэрлэх хангамжийн тоног төхөөрөмжийг тавихаар улсын төсөвт хөрөнгө оруулалт тусгагдаад, аймаг дээр тендер зарла.../минут дуусав./

С.Ганбаатар: Асууж хариулт авлаа.

Би тодруулж 2 зүйл асууя. Ер нь үйлдвэр, технологийн парк гээд нарийн яривал Монголын ард түмэн тэр чигээрээ л хүлээж байгаа юм шүү дээ. Аж үйлдвэрлэл Монголд ер нь хөгжихгүй байна. Сэхээнд орчихсон хүүхдийг чинь амь оруулахын тулд л инкубаторт оруулдаг, хиймэл амьсгаа хийлгэдэг, тусгай орчин бий болгодог л гэсэн үг л дээ. Яг Монголын хүнд, хөнгөн энэ аж үйлдвэрүүдэд тус дэм болохын тулд бид хиймэл орчин бүүр бодлогоор, татвараар болон эрх зүйн орчноороо дэмжиж хиймэл орчин бий болгоод дэмжиж байгаа. Тэгээд энэ бид 10 жил ярилаа. Инкубатор ерөөсөө л ажиллахгүй тэгээд л яваад л байна. Өнөөдөр Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо энэ асуудлыг авч ярихгүй л өөр хаа нэг газар Монгол оронд энийг авч ярих хаа, хэн ч, ямар ч бодлогын байгууллага байхгүй. Их Хурал бол данхайна томдоно. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо л барьж авна.

Тэгэхлээр түрүүн ярьж байна яамнуудаар бид явна. Очоод танин мэдэхүйн тийм зүйлүүд асуугаад, яриад уулзах биш асуудал дээр шийдэлтэй, гарцтай, гаргалгаатай, үр дүнтэй очихын тулд энэ олон асуулгууд, энэ олон ажлын хэсэг байгуулагдаж байгаа. Эндээс шийдвэр гарна, хуульд өөрчлөлт орно, шаардлага гарвал хариуцлага тооцно. Сайн байгаа туршлагаудыг нь бусдуудад нь хэрэгжүүлнэ гэж.

Тэгэхлээр миний нэгдүгээр асуулт ерөөсөө л бид л их хөнгөлөлттэй зээл, тусламж, татаас л их ярьдаг. Худалдан авагчаа олчих л юм бол 100 хувь асуудал шийдэгдэнэ гэж нэг үг байдаг юм л даа. Тэр шиг өнөөдөр энэ үйлдвэр, технологийн паркуудад бий болж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авагч нь гадаад байна уу, дотоод байна уу талаар судалгаа, шинжилгээ хийсэн яг таг нарийвчилсан зүйлүүд байгаа юу? 17 парк дээр?

Хоёрдугаарт, энэ чинь үйлдвэр, технологийн паркийн тухай ярьж байгаа шүү дээ. Бид технологийн шийдлүүдээ ярьсан уу, гарсан уу? Бид ямар нэгэн байдлаар технологийн гэрээнүүдээ технологи өндөр хөгжсөн орнуудтай урьдчилсан гэрээ хийсэн үү? Нипон стильтэй бид энэ зэс хайлах үйлдвэр, зэсийнхээ энэ баяжмалыг боловсруулаад бүтээгдэхүүн, эсвэл компонент/component/ эд ангийн бүтээгдэхүүн

хийх тийм гэрээнүүдээ урьдчилсан байдлаар хийж эхэлсэн үү? Миний хоёр дахь асуулт. Тэр арьс ширний асуудал ярьж байна. Боловсруулсан энэ арьс ширнүүдээ хаашаа гаргах гэж байгаа талаараа гэрээнүүдээ хийсэн үү?

Гурав дахь асуулт. Бидний хамгийн толгой руугаа шаадаг юм хүний нөөц. Энэ олон 17 үйлдвэр, технологийн паркуудад зориулж хүний нөөцийн бий болгож байгаа МСҮТ-үүд нь хаа байгаа юм? Энэ олон Шинжлэх ухаан, техникийн их сургууль болон энэ МСҮТ-үүдтэйгээ хүний нөөцийн талаарх бодлогын баримтуудаа бий болгосон уу, гэрээнүүдээ хийсэн үү? Гуравдугаар асуулт.

Татварын хөнгөлөлтийг их ярьж байгаа. Түрүүн Бямбацогт гишүүн маш чухал зүйл ярьсан. Боловсруулах үйлдвэрийн татварын хөнгөлөлт нь өнөөдөр үйлдвэр, технологийн паркийн хөнгөлөлтөөс илүү гарчихсан. Одоо үйлдвэр, технологийн парк дотор, инкубатор дотроо давуу байдал биш, гадна талд нь давуу байдал бий болчихсон. Татварын давуу байдал бий болчихсон. Өнөөдөр энэ дээр хариуцаж байгаа яамнууд нь шийдэл гаргаж байгаа юу? Бодлогын шийдлүүдээ Аж үйлдвэрийн байнгын хороогоороо шийдүүлэхээр та нар материалуудаа өгсөн үү? Бид хүлээж байна. Бид та нарт дэм болохыг л хүсэж байгаа. Тэр аль нам ерөөсөө улс төржсөн юм байхгүй шүү дээ. Энийг та нар биднийг бүгдийг нь хамтад нь монголын ард түмэн, аж үйлдвэрлэгч нар хүлээж байгаа. 10 жил тэвчээртэй хүлээж байгаа.

Хамгийн сүүлд 5 асуудал байдаг л даа. Би бас амьхандаа Удирдлагын академи, Санхүүд яг энэ үйлдвэр, технологийн паркаар хичээл зааж байсан хүн л дээ. Үйлдвэрчний ерөнхийлөгч байхдаа би их олон орноор үйлдвэр, технологийн паркуудаар явж байсан юм. 5 саяын гол асуудлыг л шийдэх ёстой байдаг.

Хамгийн сүүлийн асуудал нь буюу кредит, зээлийн бодлого. Зах зээлээ шийдчихсэн, хүний нөөцөө шийдчихсэн, технологио шийдчихсэн бол, татварын асуудлаа шийдчихсэн бол тэртээ тэргүй дэлхийгээр дүүрэн хөнгөлөлттэй зээл өгөх гээд хүмүүс ирдэг. Энэ зээлийн бодлогыг би асуух гээд яах вэ. Энэ дээр харин ч гэж гайгүй байх гэж бодож байна. Миний багц нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, тэр Эрдэнэтийн үйлдвэр, технологийн парк их ярьж байгаа. Элементийн хүхэр түрүүн ярьсан. Жавхланбаатар дарга ярьсан. “Арева”-гийн энэ уран руу энэ элементийн хүхрээ өгөх талаар ярилцаж ойлголцсон зүйлүүд бий юу? Би энэ 1 сар орчмын өмнө ураны тал дээр ч мөн хоолойгоо сөөтөл орилсон доо. Цаадуул чинь. элементийн хүхрийг 210 мянган тонн хүхэр, нийт төсвийн 27 хувь байлаа шүү. 20 хувь гээд байсан 27 хувийг гаднаас, гадаадаас авна гэдгээр орж ирж байгаа. Яам энэ дээр ажиллаж энэ үндсэн энэ хүхрийн элементийн хүхрүүдээ Монголоос нийлүүлэх талаараа санаачилга, санал гаргасан уу, гэрээнд тусгасан уу? Миний хоёр дахь асуулт.

Гурав дахь зүйл дээр яриад байна Ж.Энхбаяр сайд ярилаа. Ер нь хүч тарамдаж байгаа. Баахан мөрөөдлийн 17 паркин дунд бид хүчээ тарамдуулчихсан, хэнийг нь ч амь оруулахгүй байдаг. Харин ёстой улс төрийн манлайлал, бас сэтгэл гаргасны хувьд Шинэ Ховд төсөл одоо бас нохойн дуу сонсогдож байгаа. Бараг хүчээ төвлөрүүлсэн нь дээр дээ.

Тэгэхлээр ер нь хагас дутуу зээл өгнө гэдэг санхүүчдийн дунд яриа байдаг юм шүү дээ. Наад дэлгүүрийг чинь ашигтай ажиллаж байгаа захыг чинь би дээрэмдэж авъя гэвэл хагас дутуу амь орохгүй зээл өг гэж үг байдаг юм шүү дээ.

Яг тэр шиг бид зүгээр амь оруулахгүйгээр 17 үйлдвэр, технологийн паркт зээл өгч, амийг нь тасалж байгаа ийм л бодлого байна л даа. Энийг Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороон дээр л ярихгүй юм бол өөр хаана ч ярихгүй.

Тэгэхлээр энэ тал дээр энэ дампууруулах энэ мөчир тачиг, энэ амь оруулахгүй байх бодлого дээр яамнууд нь энэ дээр ямар нэгэн байдлаар бидэнд бодлогын шийдэл гаргаж ирэх үү? Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороон дээр бид ажлын хэсэг гаргаж байж ажиллахгүй бол та нараас юу ч гарахгүй юу гэсэн ийм миний гурав дахь асуулт дээр хариулах уу? Хэн нь эхэлж хариулах вэ 2 яамнаас?

4 номер Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Үнэхээр тантай санал байна. Бид асуудлыг иж бүрэн, цогцоор нь харах хэрэгтэй. Түүхий эдийн нөөц, хүний нөөц, технологи, зах зээл, санхүүжилт, даатгал, тэгээд олон улсын гэрээ, хэлэлцээр.

Тэгэхээр бид энэ шийдлийг боловсруулаад Байнгын хороондоо танилцуулъя. Үнэхээр ярих ч юм байна, ярихгүй ч юм бас байна. Ялангуяа хүний нөөцийн асуудал туйлын эмзэг. Энэ чинь маш өндөр насжилт явчихсан. Хүнс, хөнгөн үйлдвэрийн салбар, хөдөө аж ахуйн салбар тэр чигтээ хүний нөөцийн дутагдалд орж байна. Тэрийг хангах боловсон хүчин бэлдэх бодлого гэж үндсэндээ маш хүнд байдалтай байгаа.

Нөгөө талаас салбар шинжлэх ухааны суурь судалгаануудаасаа холдчихсон, хүрээлэнгүүд нь бүгд өөр яамны харьяанд шилжчихсэн, боловсон хүчнийг бэлдэж байгаа МСҮТ-үүд нь өөр яамны мэдэлд, дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлдэж байгаа сургуулиуд нь өөр яамны мэдэлд буюу шинжлэх ухаан, хүний нөөц, үйлдвэрлэл бодлого тус тусдаа явж байгаа ийм маш муу байдал. Энийг яаралтай нэгтгэн зангидаж байж хөгжлийн бодлого руугаа бүх хүчийг дайчлахгүй бол тарамдсан байдал анзаарагдаж байгаа.

Санхүүжилт мөн адилхан шүү дээ. Ёстой цувуулсаар байгаад 6 жил цувж байж Ховдын парк явж байна. Энэ жил нэлээн дөхнө. Тэр технологийн, арьс ширний яг технологийн цэвэрлэх хүчин чадал тэр тооцоо жоохон алдаадаа гарсан бол тэр нь газар дээр нь очоод засаад янзлаад бид шинээр боловсруулаад янзалчих байх. Дарханыхыг анх удаа л ярьж ярьж байж анх удаа л энэ жил төсөв тавьж байна. Тэгээд энэ төсвийн хүрээнд бид нар ажлыг нь яаралтай явуулна.

Ер нь энэ яригдаж байгаа паркуудыг хэрхэн богино хугацаанд үр ашигтай, үр дүнтэй ажиллуулах вэ, ямар хүн, хүч ажиллах нь вэ, хэчнээн төгрөгийн хөрөнгө оруулалт орох нь вэ гэсэн иж бүрэн бүх тооцоо, судалгааг бид нар хийгээд ажлын хэсэг очих үед, эсвэл Байнгын хорооны гишүүд очих үед сайхан танилцуулъя. Тэгээд ер нь газар дээр нь очоод бүгдээрээ шийдлээ хамтдаа гаргасан нь зөв болов уу гэж бодож байна. Тэгээд бид бүх талаараа хамтран ажиллана.

С.Ганбаатар: Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга 5 номерын микрофон.

С.Жавхланбаатар: Ганбаатар даргын асуултад хариулъя.

Худалдан авагчаа олсон уу гэж. Явж байгаа хувийн хэвшлийн 2 төсөл маань худалдан авагчийнхаа хөрөнгө оруулалтаар бас явж байгаа ийм кейс байгаа тохиолдол. Өөрөөр хэлбэл, өөрсдөө худалдан авагчаасаа зээл авах байдлаар хөрөнгө оруулалтаа хийж, үйлдвэрүүдээ барьж байгаа.

Эрдэнэтийн хувьд бол бид нар технологийн шийдлээ хийгээд ТЭЗҮ-ийн эхний үнэлгээг хийчихсэн байж байгаа. Германд бас одоо үйлдвэрлэлийн туршилт, Хятадад үйлдвэрлэлийн туршилт явагдаж байгаа. Энэ дээр үйлдвэрлэлийн туршилтын үр дүн дээр үндэслээд бид нар ТЭЗҮ-д тодотгол хийж, технологийн шийдлээ олно гэсэн таамагтай. Бусад кокс хими, кокс эрчим хүч, Багануур гангийн цогцолбор дээр ТЭЗҮ маань хараахан дуусаагүй байна. Тэгэхээр ТЭЗҮ дээр суурилж бид нар технологийн шийдлийг гаргана гээд.

Хүний нөөцийн асуудал хөндөгдлөө. Хүний нөөц дээр МСҮТ-үүдтэй ажиллаж байгаа таны асуусан шиг яг тэр үйлдвэр дээр тэдэн хүн гэдэг гэрээ хараахан байгуулагдаагүй байна. Ерөнхийдөө бол гадаад ажилчдыг угсралтын үед орж ирэхэд нь үндэсний боловсон хүчнээ 2-3 жилд бэлтгэнэ гэсэн төлөвлөгөө ТЭЗҮ дотор дагалдаж орж ирж байгаа. Ер нь үйлдвэрүүд дээр. Ийм байдлаар өөрийнхөө дотоод хүний нөөцийг, мэргэжилтнүүдийг бэлдэнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Одоогийн явж байгаа, эхэлчихсэн байгаа төслүүд дээр гэсэн үг.

Ер нь энэ Үйлдвэр, технологийн паркийн хууль маань дэмжлэгийн хувьд аягүй сайн хууль болсон гэж бид нар бодож байгаа яамны хувьд. Монгол Улс чинь хамгийн том баталгаа нь хөрөнгө оруулалтын л гэрээ байгаа шүү дээ. Та бүхэн мэдэж байгаа. Улсын Их Хурлаар орж байгаа Оюу толгой байна. Орано орох гэж байна.

Тэгтэл Үйлдвэрлэл, технологийн паркийн тухай хуульд энэ бүүр заагаад өгчихсөн байж байгаа. Энэ нөгөө төрөөс түрүүн Жаргалсайхан гишүүн бас асуугаад байсан дэмжлэгүүд дутуу байна гэж. Дутуу байна гэж бид нар харахгүй байгаа. Монгол Улс өгч чадах хамгийн том баталгаагаа энэ хуулиар дахиж өгсөн. Хараахан энийг ашиглая гэдэг хөрөнгө оруулагч гарч ирээгүй байна. Магадгүй бид нарын сая улсын хөрөнгө оруулалтаар дэд бүтцийг нь хийх тухайлбал, зэсийн баяжуулах үйлдвэр дээр хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна гэж хөрөнгө оруулагч орж ирэхийг үгүйсгэхгүй.

Тэгэхээр энэ хуулийн өөрийнх нь баталгаа хангалттай. Дээр нь хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийн баталгаа гаргах асуудлыг бас дэмжлэгт оруулж өгсөн хуульд. Их Хурал шийднэ. Ингээд бүх баталгаа нь байгаа байхгүй юу. Бусад Хятад, Герман гээд бид нар олон улсын юуг судалсан дэмжлэгүүдийг. Манайхаас тийм өндөр дэмжлэг байхгүй харьцуулахад.

“Арева”-тай холбоотой нөгөө хүхрийн Эрдэнэтээс гарч байгаа хүхрийн хүчлийн юуг асууж байна. Хөрөнгө оруулалтын хэлцэл яг одоо явж байна. Эцэслэгдээгүй байна. Тэгэхдээ бид нар ямар заалт оруулсан бэ гэхээр дотоодоос нэн тэргүүнд худалдан авалтыг энэ түүхий эд дээр хийнэ гэдэг заалтыг оруулсан байж байгаа. Баярлалаа.

С.Ганбаатар: Асуулт асууж, гишүүд хариулт авлаа. Үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя.

Бадамсүрэн гишүүнээр, Золжаргал гишүүн бас өгсөн юм байна шүү. Золжаргал гишүүнээр тасалъя. Ингээд Бямбацогт гишүүн үг хэлнэ.

С.Бямбацогт: Манай асуултад хариулж байгаа сайд, Төрийн нарийн хоёр бас энэ Үйлдвэр, технологийн парк сайн хууль болсон, ер нь одоо бараг үүнээс сайн хууль байхгүй л гэж байна. Санаачлаад батлуулсан хүний хувьд сайн хууль хийхийн хувьд хичээсэн. Дэлхий дээр байгаа олон үйлдвэр, технологийн паркуудын жишгийг судалж байж аль аль болох сайнуудыг нь авч Монголдоо нэвтрүүлэх гэж үзсэн.

Гэхдээ одоо бас тийм сайн биш болчихоод байна. Тэр боловсруулах үйлдвэрүүдэд 1 хувийн татвартай болж байгаа чинь энэ үйлдвэр, технологийн парк бас амь ороход бас нэлээн тийм асуудалтай болох гэж байгаа. Тийм учраас Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилсан “Цагаан алт” хөтөлбөртөө тэр үйлдвэр, технологийн паркууд дээр барих гэж байгаа, хийх хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд тэр аж ахуй нэгжийн орлогын албан татварыг эхний 5 жилд нь 100 хувь чөлөөлөх, дараагийн 5 жилд нь 6-10 дахь жилд нь 50 хувь чөлөөлөхөөс гадна тэр хүн амын орлогын албан татвар, гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар энэ бүгдээс нь чөлөөлөх асуудлыг бас цогцоор нь шийд гээд Улсын Их Хурлаас тогтоол гаргаад өгчихсөн байгаа. Улсын Их Хурлын тогтоолыг Засгийн газар хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тийм болохоор манай яг хариуцсан сайд нар маань энэ “Цагаан алт” хөтөлбөрийг дагаж гарсан Улсын Их Хурлын тогтоолыг нь хараадхаач. Тэн дээр бидэнд үүрэг өгчихсөн байгаа Засгийн газарт. Энийгээ бариад явах юм бол бид нар дахиад Үйлдвэр, технологийн паркийн хууль өшөө сайжраад энд бид нар жинхэнэ үнэ цэн бий болгох, жинхэнэ баялаг бий болгох боломж бүрдэх гээд байгаа юм. Монгол Улс нөхөн сэргээгддэг баялагтай, малын гаралтай түүхий эд, мал аж ахуй, дээрээс нь газар тариалангийн бүтээгдэхүүн, жил болгон нөхөн сэргээгдэж байдаг ноос нь, арьс шир нь, мах сүү нь, газар тариалангийн бүтээгдэхүүн ялгаа байхгүй. Энэ баялгаа нэмүү өртөг шингээгээд олон ажлын байр бий болгоод ингэх юм бол олон хүн ажилтай болно, хүнсний асуудлаа шийднэ, экспортын орлого нэмэгдэнэ.

Нөгөөд талд нь уул уурхайн бүтээгдэхүүн нөхөн сэргээгддэггүй. Ухаад л аваад явчихдаг. Энэ зэсээ хайлуулаад зэсийн баяжмал хийдэг болчихъё. Тэгээд цэвэр зэс гаргадаг болчихъё, цэвэр зэсээрээ бид нар зэс бүтээгдэхүүн хийдэг болчихъё. Маш их валютын нөөц бидэнд бий болно, асуудлаа шийднэ. Энэ нүүрсээ гаргаж байхыг нь кокс болгоё. Тэр төмрийн хүдрийг түүхийгээр нь гаргаж байх оронд ширэм хайлуулаад ширэм хийе. Энэ хэмжээгээр чинь бид валютын орлого нэмэгдэнэ. Ийм л боломжуудыг бий болгох гээд байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол үйлдвэр чухал. Энэ үйлдвэрүүдийг төрөөс бодлогоор дэмжээд барьчих юм бол олон мянган ажлын байр бий болно, Монгол Улсын валютын нөөц нэмэгдэнэ, Монгол Улсын төсвийн орлого нэмэгдэнэ. Монгол Улсын эдийн засаг өөрөө томорно, тэлнэ. Ийм л олон зорилготой хууль. Тэгээд энийг бас яг энэ талаас нь хараад та бүхэн маань бас тэр холбогдох хуулийн өөрчлөлтүүдийг хийгээч ээ гэдгийг нэгдүгээрт нь хүсье.

Хоёрдугаарт нь Дондогдорж даргаа та бас бас асуудлаа сайн ойлгохгүй, бас мэдэхгүй байгаад байна. Тэр “Саруул цамхаг” гэж компанийн барьсан цэвэрлэх байгууламж чинь ахуйн цэвэрлэх байгууламж болсон. Энийг мэргэжлийн хүмүүс нь

яваад үзээд ерөөсөө энд малын арьс шир боловсруулж болохгүй. Энд химийн бодис ордог учраас тусдаа тусгайлсан ийм тусад нь цэвэрлэх байгууламж барих шаардлагатай гээд тэрнийх нь дагуу зураг төсөв хийгээд, тэр үйлдвэрлэлийнх нь паркийн захиргааныхан бүх юм, төсөв нь бэлэн болчихсон байж байгаа. Тэгж 2 цэвэрлэх байгууламжтай байж байж тэр арьс шир боловсруулах үйлдвэрлэл, технологийн парк маань иж бүрнээр ажиллах боломжтой болох юм.

Гэтэл та хариуцсан ажлаа мэдэхгүй суугаад байгаа байхгүй юу. Энд чинь би харамсаад байгаа юм. Олон жил би танд бас хэлж байгаа. Энэ дээр анхаарал тавиад бас хөдөө аж ахуйн сайд очих гэж байна. Аж үйлдвэржилтийн байнгын хорооны гишүүд бас бүгдээрээ очъё гэж байна. Хамгийн амжилттай явж байгаа төслийг хурдан хугацаанд ашиглалтад оруулаад загвар жишиг болгоё гэж байна. Тэр үед нь та бас урьдчилаад асуудлыг нь, шийдлүүдийг нь гаргачхаад ингэчих юм болчих гээд байна, ингэхийн тулд Аж үйлдвэржилтийн байнгын хороо дэмжээд өгөөч, ингэхийн тулд сайд, Засгийн газрын гишүүд дэмжээд өгөөч гээд бидэнд их шийдэлтэй түрүүлж очоод бас шийдэл гаргаад байж байгаа.

Тэгээд бас манай Аж үйлдвэржилтийн байнгын хорооны гишүүд, манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд маань бас очоод газар дээр нь бид бүхэн бас хамтраад асуудлыг шийдэхийн төлөө ажиллая. Та тэгэхээр ажил руугаа жоохон ороод өгөөч ээ. Жоохон мэдээллээс жоохон хол яваад байна шүү гэдгийг бас танд бас хэлье.

С.Ганбаатар: Жаргалсайхан гишүүн үг хэлнэ.

Д.Жаргалсайхан: Арьс ширний энэ зах зээлийг бас хэдүүлээ сайн судлахгүй бол жишээ нь бид нар үйлдвэрээ бариад ашиглалтад орчихлоо, бүтээгдэхүүнээ үйлдвэрлэчихлээ, үйлдвэрлэлийн зардал 6, 7 мянган төгрөг болж байна. Тээврийн зардалтайгаа Хэбэй-д очиход 10 мянган төгрөг болж байна.

Гэтэл арьс шир маань тэндээ яг боловсруулсан нь 10 мянган төгрөгтэй байгаа байхгүй юу. Тийм учраас л эндээс арьс шир авахгүй байгаа шүү дээ. Туркт бол 12 мянгатай л байна жишээ нь. Энийг мэдэж байгаа тээ Хөдөө аж ахуйн сайд? Тийм л байгаа тээ? Тэгэхээр бид нар Бямбацогт сайдын ярьж байгаа томоохон үйлдвэрүүдээ л дэд бүтцээ бариад ашиглалтад орчихсоны дараа боловсруулсан бүтээгдэхүүн чинь өөрөө яг тэрнээсээ илүү зардал гаргачхаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг бид нар яаж тооцож байгаа юм бэ, энэ эрсдэлийг яаж тооцож байгаа юм бэ? Эс үгүй бол бүтээгдэхүүн гутал үйлдвэрлэх юм уу? Энэ чинь эргээд л бид нарын хариуцлага унана шүү дээ. Толгой дээр. Ийм судалгаа байна уу л гэж асуугаад байгаа юм би.

Дээрээс нь сая Бямбацогт гишүүн хэлж байна. Бид нар энэ томоохон энэ аж үйлдвэр, тэр тусмаа энэ уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах дээр бол маш том улс төрийн дэмжлэг, бодлого байж байж дэлхийн энэ томоохон бүтээгдэхүүнүүдтэй өрсөлдөхөөр болсон. Бид нар хуулиа гаргачихлаа. Та нар ороод ир ээ, бид нар бэлэн шүү гээд сууж байдаг цаг хугацаа ерөөсөө байхгүй болсон. Бүүр би тодорхой энд хэлэх юм бол бүүр үндэсний томоохон аж ахуйн нэгжийг бүүр хариуцлагатай томоохон үндсэн аж ахуйн нэгжийг сонгож аваад, сая бид нар Хөгжлийн банкнаас сая тэр цементийн үйлдвэрүүд тэр 4, 5 жилийн хугацаатай л гэрээ өглөө шүү дээ, зээл өглөө шүү дээ. Яг үнэн чанартаа л үйлдвэрээ барьж дуусаагүй байхад л зээлийг нь нэхээд эхэлж байгаа байхгүй юу. Тийм биз дээ? Барилгаа бариад, үйлдвэр туршилтаа бараг хийгдээд юун ашиг,

юун зээлийн эргэн төлөгдөх тийм хугацаа байхгүй шүү дээ. Тэгэхээр бид нар өнөөдөр ийм хэмжээний юм яриад сууж байгаа байхгүй юу.

Тэгэхээр үндсэндээ яг энэ дэлхийн энэ томоохон энэ зах зээлтэй өрсөлдөхийн тулд 20, 30 жилийн хугацаатай, хүү байхгүй, татвараас бүрэн чөлөөлж байж ингэж өрсөлдөж байж л бид нар тэр томоохон өрсөлдөөнөөс гарч ирнэ. Иймэрхүү байдлаар харвал яасан юм бэ гэдгээ энд том бодлогын юм ярьж байна шүү дээ. Тэрнээс хэдүүлээ юу гэдэг юм арьс шир боловсруулъя гэж яриагүй байна шүү дээ. Би энэ Уул уурхайн яаман дээр ийм том хэмжээний бодлогын юм оруулж ирээсэй гэж бодож байна. Үнэхээр түүхий эд бид нарт байгаа бол байгаа. Тэгээд үнэн. Энэ дээр ямар судалгаа байдаг юм? Тэр Хятад, Америктай адилхан гэнэ, үгүй шүү. Дор хаяж л яг энэ хөрөнгө оруулалт их хараад сууж байдаггүй юм байна лээ. Яг улсаас нь бодлогоор, яг энэ компани, энэ үйлдвэрлэл, энэ түүхий эдэн дээр, энэ орд дээр ийм бүтээгдэхүүн гаргана. Дэлхийн ийм ийм зах зээлтэй ингэж өрсөлдөхийн тулд бид нар ийм хугацаанд гээд бүр 20, 30, 40 жилийн хугацаатай төлөвлөгөө гаргаж байгаад ажилладаг юм байна лээ шүү. Тэгээд энэ талаар ярьж өгөөч ээ. Хэдүүлээ жоохон сая тонн доторх үйлдвэр яриад байна шүү. Үгүй шүү бүүр. Тэрнээс хэдэн саяын том үйлдвэрээр бид нар өнөөдөр өрсөлдөнө шүү.

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүн үг хэлье.

М.Бадамсүрэн: Монголчууд манайд үйлдвэр байсан тэгээд одоо яагаад болохгүй байгаа юм бэ л гэж л ялангуяа ахмадууд л их асуугаад байгаа юм л даа. Тэгж ойлгоод байгаа юм. Тэгээд яах вэ тухайн үед социалист нийгэм байсан, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг, гадаад талдаа Социнтерний орнуудад мах, түүхий эдээ борлуулдаг, малын түүхий эдийн чанар харьцангуй сайн, эрүүл байсан гээд олон зүйлүүд байгаа л даа. Тэгэхээр энэ хоёр нийгмийн хоорондын ялгааг бид нар маш сайн ойлгох хэрэгтэй байгаа юм. Түүнээс механикаар л үйлдвэр байсан, байх ёстой гэж бодох биш. Энэ маш том ийм ялгаатай ойлголт байгаа.

Тэгэхээр сая Бямбацогт сайд, Жаргалсайхан гишүүн хоёртой би 100 хувь санал нэг байгаад байгаа. Ер нь бид нарын санал давхардаж байна гэсэн үг л дээ.Тэгэхийн тулд энэ үйлдвэрүүдийг дэмжинэ гэдэг зүйлийг лоозон болгож ярихаас илүүтэй нэгдүгээрт газар олголт дэмжих ёстой.

Хоёрт, хөнгөлөлттэй зээл. Тэгээд энэ чинь нөгөө хөнгөлөлттэй зээл олгоод сайхан үйлдвэр ажиллаад ирвэл олон хүн ажиллахаар тэр хүний цалин хөлсний орлого, нийгмийн даатгал, амьжиргааны түвшин нэмэгдэнэ, гэмт хэргийн гаралт бууна гээд л ийм олон л хүчин зүйл, сайн үр дагавар байгаа юм л даа. Тийм учраас бид нар энийгээ маш том тооцоолохгүй л зогсонги байгаад байвал байгаад л байх учраас хөнгөлөлттэй зээлийн бодлогыг л нэмэгдүүлэе л гээд би бол байнга л энэ саналаа дэвшүүлээд байгаа. Энийг Монгол Ардын нам сонгуульд оролцохдоо дэвшүүлсэн манай том л бас мөрийн хөтөлбөрийн заалт л даа. Хөнгөлөлттэй зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ, эх үүсвэрийг нэмэгдүүлнэ ээ л гэж байгаа ерөөсөө.

Тэгэхгүй бол энэ зах зээлийн эдийн засаг чинь төр, бизнес хийхгүй, зөвхөн хувийн хэвшил хийнэ. Төр бол хувийн хэвшлийн бизнес хийхийг л дэмжинэ. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ, өрхийн зарлагыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ. Өрх айл бүр үйлдвэрлэгч байх, өрх айл бүр хүлэмжийн аж

ахуй эрхэлдэг, мал аж ахуйгаа эрхэлдэг, тариалан эрхэлдэг, ингээд орлого нь нэмэгдвэл энэ олон сөрөг үр дагаврыг бууруулах ач холбогдолтой.

Тийм учраас энэ зүйл рүү бүхэлдээ чиглэхгүй бол бид нар үндсэндээ тийм хэрэглээний чиглэл рүү явсаар байгаад яг энэ зүйл дээр нээрээ тийм сайн төвлөрч чадахгүй байна. Тэгэхээр Монголын төр юм бол энэ дээр дорвитой өөрчлөлт хийх ёстой. Тэгээд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энэ Эрдэс баялгийн яам энэ зоригтой бодлогуудыг оруулж ирээч ээ л гэж би хүсэж байна. Тэгээд энэ бол Улсын Их Хурал хараад байхад сайд нар бодлогоо зөв гаргаад Засгийн газар дэмжээд ороод ирвэл цаашаа явах боломж байна шүү дээ. Нөхөн сэргээгддэггүй уул уурхайн салбараас бид нар их хэмжээний л орлого олж байна. Энэний нөхөн сэргээгддэг салбар руу буюу ургадаг энэ хөдөө аж ахуйн салбар руу заавал оруулах ёстой. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах ёстой.

Одоогийн бүх иргэдэд орон сууц, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ авах, ирээдүйд хүүхдүүддээ мөнгө хадгалахаас нэмээд энэ нөхөн сэргээгдэх салбар руугаа дорвитой мөнгө оруулж, ингээд тухайн жилд төсвийн жилд яах бол, ийх бол, хэдэн төгрөг төсөвлөх биш ерөөсөө бодлого нь тогтвортой байх хэрэгтэй болж байгаа юм. Томоохон уул уурхайн баялгийн орлогын тэдэн хувь нь шууд нөхөн сэргээгддэг хөдөө аж ахуйн салбартаа, хүнсний салбартаа ордог энэ бодлогыг хослуулж явахгүй бол цаашдаа л тийм төсвөөс ийм хараат байдалтай, тухайн үед төсөв яаж батлах гээд л уур амьсгал тухайн үед парламент ямар байх вэ гээд энэ зүйлээс ангижирч л энэ Үндэсний баялгийн сангийн тухай хууль дээр ийм өөрчлөлтийг заавал оруулах хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байгаа. Тэгээд энийг бас 2 яам хамтарч анхаараач. Манай Аж үйлдвэржилтийн байнгын хороонд энэ 2 яам гол харьяалагдаж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ тал дээрээ хамтарч ажиллая гэдэг саналыг л би энэ Байнгын хорооны гишүүний хувьд дэвшүүлж байгаа юм. Ингэхгүй бол бид нар энэ зүйл анхаарахгүй болохгүй. Тэгээд Дорнодод олон үйлдвэр бас байгуулах боломж байгаа шүү. Эрчим хүч, боомттой.

С.Ганбаатар: Золжаргал гишүүн үг хэлье.

Ж.Золжаргал: Аж үйлдвэржилтийг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байгаа та бүхний ер нь асуудлуудыг сонсоод би 3 зүйл тэмдэглэж авлаа л даа. Тэгээд асуудлыг сонслоо. Одоо хэрэгжүүлэх талаар ийм цаасан дээр буулгаад Байнгын хороон дээр хүргүүлбэл ямар вэ гэж хүсмээр байна. Байнгын хорооны дарга болоод гишүүд бүгдээрээ л аж үйлдвэржилтийг дэмжиж байгаа байр суурь илэрхийлээд байгаа учраас. Юу гэхээр зэрэг нэгдүгээрт аж үйлдвэрийн паркууд байгуулагдаж байна. Түүхий эдээ яаж хангах нь тодорхойгүй байна. Тэгэхээр түүхий эдийг нь хангахын тулд бид нар ямар шийдвэр гаргах ёстой юм.

Хоёрдугаарт, нь энэ одоо ажиллаж байгаа баяжуулах үйлдвэрүүд нүүрс аваад баяжуулъя гэхээр зэрэг Биржийн хуулиар хил нөхцөлөөр тээвэрлэж өгөх ийм нөхцөлтэй болчихсон. Тэгэхээр хил дээр аваачиж Хятадын хил рүү оруулах үнээр биржээр худалдаж авчхаад буцаагаад Монголын ..рүү тээвэрлэж байгаад баяжуулна гэж байхгүй. Тэгэхээр тэр дээр ямар зохицуулалт байх юм? Энийг нь шийдэж өгөөд, мөнгө оруулаад барьчихсан үйлдвэрүүдийг нь ажиллуулмаар байна. Тэгэхээр энэ дээр ямар шийдэл байх вэ та бүхэн цаасан дээр буулгаач.

Гуравдугаарт нь нөөцийн төлбөрийг баяжуулаад яахаар урьд нь авсан хасалт нь хийгддэггүй давхар төлдөг гэдэг гомдол тасрахгүй байгаад байна. Энийг нэг тийш нь болговол яасан юм бэ гэсэн. Тэгээд энэ танилцаад, хэлэлцээд, чиглэл гаргадаг сан уу, тогтоол гаргадаг сан уу, шаардлагатай бол бас эрх зүйн баримт бичиг дээр нэмэлт, өөрчлөлт оруулах ийм саналыг энэ Байнгын хороо чиг үүргийнхээ хүрээнд гарах талаар бодолцох болов уу гэж бодож байна.

С.Ганбаатар: Үндсэндээ гишүүд үг хэлж, байр сууриудаа илэрхийллээ. Ингээд 2 яамнаас Энхбаяр сайд, Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга маш их чухал бас мэдээллүүд хийлээ. Баярлалаа.

Ер нь үйлдвэрлэл, технологийн парк цаад утгаараа аж үйлдвэржилт гэдэг Монголын ард түмний мөрөөдөл. Маш олон хүмүүсийг ажилтай, орлоготой байлгана л гэж бид мөрөөдөж байгаа. Тэгээд олон жил мөрөөдөж байна. Энэ ингээд эзэн биегүй л яваад л байвал яваад л байна. Тэгээд л нэг л учир нь олдохгүй яваад байдаг биш. Үндсэн хууль дээр, Үндсэн хуулийн 20-д заасан байгаа шүү Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллага эрх зүйн энэ хууль тогтоох гагцхүү Улсын Их Хуралд энэ хууль тогтоох үйл ажиллагаа байгаа. Улсын Их Хуралд. Өөр хэнд ч биш.

Өнөөдөр аж үйлдвэржилттэй холбоотой эрх зүйн орчныг бий болгоход цаад утгаараа Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо анхааръя гээд. Тэгээд би ч хэд хэдэн удаа л Их Хурлын гишүүн боллоо. Яг үе үеийн Их Хурлын гишүүд л ер нь яах вэ, юу хийх вэ? Баахан амлалт өгөөд гараад ирчихсэн яах вэ л гэж санаа зовж байгаа. Бид ч гэсэн адилхан энэ дээр шийдэл гаргамаар байна. Та нар маань идэвхтэй ажиллана гэж бодож байна.

Ингээд биднээс мэдээлэл авлаа. Мэдээллийн дагуу удирдамж батлаад ажлын хэсгээ бид байгуулна. Ажлын хэсгээ байгуулсны дараа ажлын хэсэг яамнууд болон үйлдвэрлэл, технологийн паркууд дээр очиж газар дээр нь асуудлууд, бэрхшээлүүдээ танилцаж үзээд шийдэл, гарц гаргалгаа гаргана. Шийдвэр хариуцлага тооцох уу, бас сайнуудыг нь бас дэлгэрүүлэх хамгийн гол нь. Их Хурал дээр ирээд болохгүй байгаа эрх зүй бас орчин байвал өөрчилье гэдэг ийм шийдлүүд гаргана. Ингээд ийм халуун өрнүүн сэтгэлээр бид өнөөдөр бас сонсголоо хийлээ. Ажлын хэсгээ гаргаж ажиллана.

Өнөөдрийн хуралдаан дээр үйл ажиллагаа сонсголыг амжилттай хийлээ. Өнөөдрийн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье.

16.54 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

